



**ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ**



**ЖАЙКА ОЛОН УЛСЫН ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА**

# **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа**

## **Мэдээллийн лавлах**

Улаанбаатар хот  
2017 он

## ГАРЧИГ

Өмнөх үг .....	3
<b>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ТОО МЭДЭЭЛЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ .....</b>	<b>5</b>
Хууль эрх зүйн орчин .....	5
Үйл ажиллагаа ба арга зүй .....	6
Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ .....	9
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ БА БОДЛОГО .....</b>	<b>10</b>
Хууль эрх зүйн орчин .....	10
Үйл ажиллагааны хэрэгжилт .....	13
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ: НИЙГМИЙН ХАМГААЛАЛ .....</b>	<b>14</b>
Нийгмийн даатгал .....	14
Нийгмийн халамж .....	17
<b>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ .....</b>	<b>22</b>
Хөдөлмөр эрхлэлт .....	22
Мэргэжлийн боловсрол, сургалт .....	25
<b>ТАВДУГААР БҮЛЭГ: ЭРҮҮЛ МЭНД .....</b>	<b>31</b>
Хууль эрх зүйн орчин .....	31
Үйл ажиллагааны хэрэгжилтийн байдал .....	32
Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ .....	34
<b>ЗУРГААДУГААР БҮЛЭГ: БОЛОВСРОЛ .....</b>	<b>35</b>
Хууль эрх зүйн орчин .....	35
Үйл ажиллагааны хэрэгжилт .....	37
Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ .....	39
<b>ДОЛООДУГААР БҮЛЭГ: ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ .....</b>	<b>40</b>
Дэд бүтцийн хүртээмж .....	40
Мэдээллийн хүртээмж .....	46
<b>НАЙМДУГААР БҮЛЭГ: БУСАД .....</b>	<b>48</b>
Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах .....	48
Олон улсын хэмжээнд дагаж мөрдөх баримт бичиг .....	48
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гамшгаас хамгаалах, сургалт сурталчилгааны ажил..	49
Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ .....	50
<b>ХАВСРАЛТ МАТЕРИАЛ .....</b>	<b>52</b>
Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он .....	52
Үндэсний хөтөлбөр батлах тухай Монгол Улсын 2017 оны 321 дүгээр тогтоол .....	72
Гадаадын хэрэгжүүлэгч донор байгууллагуудын жагсаалт .....	87
Хөгжлийн бэрхшээлийн талаарх судалгаа .....	89
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн статистик тоон мэдээлэл.....	92
Монголын ХБИ-ийн ТББ болон дэмжигч ТББ-уудын жагсаалт .....	95

## Өмнөх үг

Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, оролцоог дэмжих, хамгааллыг сайжруулах хүрээнд бодлого, эрх зүйн орчноо сайжруулах, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Энэ хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгэмсэтгэл зүйн хэрэгцээт үйлчилгээг авах, бусдын нэгэн адил амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн хамрагдах, оролцохыг дэмжих, соёл урлаг, спортын арга хэмжээнд тэгш хамруулах, авъяас чадварыг нь нээн хөгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүнд урлаг, соёлын бүтээл хүртээмжтэй байх асуудлыг боловсронгуй болгох зорилгоор 2016 онд Улсын Их Хурлаас Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна.



Тус хуулийг хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өмнө тулгамдаж байгаа эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийтийн тээвэр, зам, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн хүртээмж гэх мэт олон асуудлыг шийдвэрлэх эрх зүйн үндэс бүрдээд байна.

Түүнчлэн хуулийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хамгааллын үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын үйл ажиллагаа хүн төрөхөөс эхлээд насан эцэслэх хүртэл хүний амьдралын бүхий л цаг хугацаатай шууд холбоотой төдийгүй хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, орлого багатай ядуу хэсэг, ажилгүйчүүд, хүчирхийлэлд өртөгсөд зэрэг нийгмийн хамгийн эмзэг хэсгийн эрх ашгийг хамгаалан ажилладаг онцлогтой салбар. Энэ утгаараа манай салбарын үйл ажиллагаа бүхий л иргэдэд нээлттэй байх ёстой байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээллийг багцлан хүргэх энэхүү “Мэдээллийн лавлах”-ыг бэлтгэн хэвлүүлэхэд бүхий л талаар дэмжин тусалсан Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”-ийн хамт олонд талархал илэрхийлье.

*Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газрын дарга,  
“Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн  
оролцоог дэмжих төсөл”-ийн зохицуулах зөвлөлийн дарга  
С.Тунгалагтамир*

## Өмнөх үг

Хөгжлийн бэрхшээл гэдэг нь хувь хүндээ биш нийгэмд байгаа гэж үздэг “Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн загвар”-ын ойлголт Монгол Улсад хараахан нийтлэг болоогүй байгаа билээ. Тэр утгаараа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сул дорой хүмүүс гэсэн ойлголт давамгайлж, тэдний нийгмийн оролцоо бодит байдал дээрээ хангагдаж чадахгүй байсаар байна.

Юуны өмнө Монгол Улсад анх удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн ном хэвлэн гаргаж байгаад баяр хүргэе.



Иймд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн төрийн бодлого, арга хэмжээ, цаашдын зорилтын талаар ард иргэдэд зориулсан мэдээллийг нэгтгэн, олон нийтийн хандлага, ойлголтыг сайжруулах зорилгоор энэхүү мэдээллийн номыг гаргаж байгаа юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлого, хууль тогтоомж, бусад холбогдох мэдээллийг ойлгомжтой байдлаар цэгцэлж, тэдний эрхийг ханган ажилладаг төр болон төрийн бус байгууллагууд, гэр бүлийн хүмүүсийг мэдээллээр хангахад энэхүү мэдээллийн номын эмхэтгэл дэмжлэг үзүүлэх болно. Эмхэтгэл нь зөвхөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам төдийгүй бусад салбар яамд, газрууд, төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог хангахад түлхэц болно гэж бодож байна.

Тус эмхэтгэл нь зөвхөн нэг удаагийн хэвлэл биш бөгөөд жил бүр Монгол Улсын Засгийн газрын бодлого, арга хэмжээний талаарх шинэхэн мэдээллийг тусгах болно. Ингэснээр 10, 20 жилийн дараа хөгжлийн бэрхшээлийн салбарын төрийн бодлогын шинэчлэл, уламжлал, залгамж холбооны түүхийг өгүүлэх чухал баримт болно гэж бодож байна.

Цаашид бид энэхүү мэдээллийг цахим хуудсаар дамжуулан илүү хүртээмжтэй хэлбэрээр түгээж, хөдөө орон нутагт ч хүргүүлнэ.

Энэхүү эмхэтгэл нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний төлөө сэтгэл зүтгэлээ зориулан ажилладаг хэн бүхний ширээний ном болно гэдэгт итгэлтэй байна.

*“Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй  
иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл”*

*Ахлах зөвлөх Чибя Хисао*

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

### Статистик мэдээлэл

Энэ бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг гаргах үндэслэл болох хууль эрх зүйн орчин, мэдээллийн эх үүсвэр, арга зүй, тооцож буй үндсэн үзүүлэлт, тулгарч буй хүндрэл бэрхшээл болон цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар танилцуулж байна.

#### Ойлголт, тодорхойлолт

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д зааснаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулна.

Албан ёсны статистикийн мэдээлэл буюу Нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээнд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүнийг хамруулж байна. Хөгжлийн бэрхшээлийн төрлийг төрөлхийн ба олдмол гэсэн ангиллаар тодорхойлсон. Тухайн хүнд удамшлын шинжтэйгээр бий болсон хөгжлийн бэрхшээлийг төрөлхийн, амьдралын явцад бий болсон хөгжлийн бэрхшээлийг олдмол гэсэн төрөлд хамааруулж байна.

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр нь бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согог нь тухайн иргэнд ямар байдлаар илэрч байгаатай холбоотой бөгөөд харааны, ярианы, сонсголын, хөдөлгөөний, сэтгэцийн, бусад (эдгээрээс бусад болон хавсарсан) гэсэн 6 ангиллаар авч үзэж байна.

#### **1) Холбогдох хууль тогтоомж**

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулах, шинжлэн судалж, тооцон гаргахад дараах хууль эрх зүйн баримт бичиг, хөтөлбөр, дэлхийн болон үндэсний хэмжээний хөгжлийн стратегийг үндэслэл болгон ажиллаж байна. Үүнд:

##### 1. Хууль:

- Монгол Улсын Статистикийн тухай хууль (2016)
- Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)

##### 2. Хөтөлбөр:

- Албан ёсны статистикийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2017-2020)

##### 3. Конвенц:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (Монгол Улс 2009 онд соёрхон баталсан)
- Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (Монгол Улс 1990 онд соёрхон баталсан)

##### 4. Хөгжлийн стратеги:

- Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт - 2030
- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030
- Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодитой болгоё” Инчеоны стратеги

Монгол Улсын Засгийн газар нь дээр дурдсан конвенц, хууль, урт болон богино хугацааны хөтөлбөр, стратегийг хэрэгжүүлэх, бодлогыг төлөвлөх, тэдгээрийн хэрэгжилтийг үнэлж, дүгнэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг ашиглаж байна.

## 2) Үйл ажиллагаа ба арга зүй

### Мэдээллийн эх үүсвэр

Дэлхийн улс орнууд 1800 оноос хойш хөгжлийн бэрхшээлийн талаарх тоо мэдээллийг цуглуулж эхэлсэн бөгөөд сүүлийн 60 жилд энэ төрлийн мэдээллийг цуглуулах улс орны тоо нэмэгдэж байна. АНУ, Энэтхэг болон Португал зэрэг улсууд 19 дүгээр зууны туршид хүн амын тооллогын асуулгандаа хөгжлийн бэрхшээлийн асуултыг оруулж судалсан түүхтэй байдаг. Өнөөгийн байдлаар дэлхийн 198 улс орнууд 700 гаруй тооллого, өрхөд суурилсан түүвэр судалгаагаар хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээллийг гаргаж байна<sup>1</sup>.

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг албан ёсны статистик болон захиргааны бүртгэл мэдээллийг авч ашиглаж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлийн асуудал нь олон салбарт хамаарагдах асуудал учраас салбар бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тоо мэдээллийг гаргахад чиглэгдэж байна.

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу Үндэсний статистикийн хорооноос баталсан аргачлал, үзүүлэлтээр гаргаж байгаа, мөн статистикийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан мэдээллийг албан ёсны статистикийн мэдээлэл гэж ойлгоно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх албан ёсны статистик мэдээллийг дараах үндсэн 3 эх үүсвэрээс гаргаж байна. (Хүснэгт1) Үүнд:

- Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (НЗҮ-1)-гээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаан, хөгжлийн бэрхшээлийн хэлбэрийг харуулсан мэдээллийг жил бүр гаргаж байна. Энэ мэдээнд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон хүнийг хамруулж байна.
- Хүн амын орон сууцны тооллого: Монгол Улсын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүн ам зүй, нийгэм эдийн засгийн болон ахуйн нөхцөлийн үзүүлэлтийг цогцоор судлан тодорхойлох зорилгоор Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор анх удаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулж нийтэд тархаасан юм.
- Өрхөд суурилсан түүвэр судалгаа: Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөөлж болохуйц тодорхой хэсгийг сонгон авч дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийх замаар бодлого хөтөлбөрийн үр дүнг дүгнэх, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны суурь мэдээллийг тодорхойлж байна. Үндэсний статистикийн хороо нь тогтмол хугацааны давтамжтайгаар өрхөд суурилсан түүвэр судалгаануудыг зохион байгуулдаг бөгөөд эдгээр судалгаанууд нь өөр өөрийн гэсэн тодорхой зорилго, агуулгын хүрээнд боловсруулагдсан арга зүйг ашигладаг. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд дэлгэрэнгүй асуулгыг тэгш тоотой жилүүдэд ашиглаж байгаа бөгөөд энэ онуудад хүн амын эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлийг судалж байна. Харин Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлага судалгааг 2017 онд анх удаа зохион байгуулж явуулсан бөгөөд уг судалгаагаар Вашингтон бүлгийн хөгжлийн бэрхшээлийн богино багц асуултын хүрээнд 15-64 насны эмэгтэйчүүдийн хувьд хөгжлийн бэрхшээлийн байдлыг судалсан юм.

<sup>1</sup> Washington group: History of disability measurement and data availability

Хүснэгт 1. Мэдээллийн эх үүсвэр, төрлөөр

Үндэсний статистикийн хороо		Засгийн газар	
Албан ёсны статистикийн статистик	<b>Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (жил бүр)</b> <ul style="list-style-type: none"> <li>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нас, хүйс, төрөл, хэлбэр</li> </ul>	Захиргааны бүртгэл, тайлан	<b>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам</b> <ul style="list-style-type: none"> <li>Сургуулийн өмнөх боловсрол, Ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо</li> </ul>
	<b>Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого</b> <b>Хүн ам, өрхийн мэдээллийн сан</b> <ul style="list-style-type: none"> <li>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нас, хүйс, төрөл, хэлбэр</li> </ul>		<b>Эрүүл мэндийн яам</b> <ul style="list-style-type: none"> <li>Бүх шатлалын эмнэлгээр үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо</li> </ul>
	<b>Өрхөд суурилсан судалгаа:</b> <ul style="list-style-type: none"> <li>Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа</li> <li>Ажиллах хүчний судалгаа</li> <li>Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлагын судалгаа</li> <li>Хүүхэд хөгжил судалгаа (Хөвсгөл аймаг, Улаанбаатар-Налайх дүүрэг)-2016</li> <li>Вашингтон бүлгийн өргөтгөсөн багц асуултын ойлгомжтой байдлыг турших судалгаа</li> </ul>		<b>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам</b> <ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар</li> <li>Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо</li> <li>16 насанд хүрсэн одой хүний тоо, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр, тэтгэмж авагчид</li> <li>Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар</li> </ul>

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх бодлого, хөтөлбөр боловсруулах, үнэлж дүгнэхэд албан ёсны статистикийн мэдээллийн буюу Үндэсний статистикийн хорооны Нийгмийн зарим үзүүлэлтийн жилийн мэдээг ашиглаж байна.


Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Эрүүл мэндийн яам болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны бүртгэл мэдээллээр Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссоор хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлогдсон хүмүүсийн талаарх мэдээлэл буюу сургуулийн өмнөх боловсрол, суурь боловсрол, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүх шатны эмнэлэгт хандсан хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх тоо мэдээлэл гарч байна.

### Үндсэн үзүүлэлт

Албан ёсны статистик буюу Нийгмийн зарим үзүүлэлтийн 2017 оны мэдээллээр Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй 103.6 мянган иргэн (нийт хүн амын 3.3 хувь) байгаагийн 57.3 мянга нь эрэгтэйчүүд, 46.3 мянга нь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлийн иргэдийн 42.8 хувь нь төрөлхийн, 57.1 хувь нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна. Энэ нь хүн амын дунд олдмол байдлаар хөгжлийн бэрхшээлтэй болох тохиолдол өндөр байгааг харуулж байна.

Улаанбаатар хотын хувьд 2017 оны байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 34.2 мянган иргэн байгаагийн 18.3 мянга нь эрэгтэйчүүд, 15.8 мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, төрлөөр, 2017 он



Олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэл өндөр байгаа нь манай улсын нийт хүн амын өвчлөл, нас баралтын голлох шалтгааны нэг нь осол болж байгаатай холбоотой байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн амыг хөгжлийн бэрхшээлийн төрлөөр, насаар авч үзэхэд бага, залуу насныхны дунд төрөлхийн хөгжлийн бэрхшээлийн тохиолдол өндөр байснаа нас ахихын хэрээр олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эзлэх хувь нэмэгдэх хандлага байна. (Хүснэгт 2) Энэ хандлага Улаанбаатар хотын хувьд ч адил байна.

Хүснэгт 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, насны бүлэг, төрлөөр, 2017 он

Насны бүлэг	Бүгд		Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр			
			Төрөлхийн		Олдмол	
	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>103 630</b>	<b>100.0</b>	<b>44 384</b>	<b>42.8</b>	<b>59 246</b>	<b>57.1</b>
0-14	8 835	100.0	6 656	75.3	2 179	24.0
15-17	2 618	100.0	1 759	67.1	859	32.8
18, түүнээс дээш	92177	100.0	35 969	39.0	56208	60.9
<b>Улаанбаатар</b>	<b>34 246</b>	<b>100.0</b>	<b>14 106</b>	<b>41.1</b>	<b>20 140</b>	<b>58.8</b>
0-14	3 617	100.0	2 875	79.4	742	20.5
15-17	830	100.0	620	74.6	210	25.3
18, түүнээс дээш	29 799	100.0	10 611	35.6	19 188	64.3

Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амыг хөгжлийн бэрхшээлийн хэлбэрээр авч үзэхэд хөдөлгөөний бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 19.9 хувь (20.6 мянга), ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн бага буюу 4.0 хувь (4.2 мянга) байна. Харин Улаанбаатар хотод сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн их буюу 17.7 хувь (6.0 мянга), ярианы хөгжлийн бэрхшээлтэй хүн ам хамгийн бага буюу 4.6 хувь (1.5 мянга) байна.<sup>2</sup>

Хүснэгт 3. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ам, хэлбэрээр, 2017 он

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр	Улсын хэмжээнд		Улаанбаатар хот	
	Хүний тоо	Дунд эзлэх хувь	Хүний тоо	Дунд эзлэх хувь
<b>Бүгд</b>	<b>103 630</b>	<b>100.0</b>	<b>34 246</b>	<b>100.0</b>
Харааны	11 071	10.6	3 068	8.9
Ярианы	4 228	4.0	1588	4.6
Сонсголын	8 554	8.2	2 810	8.2
Хөдөлгөөний	20 688	19.9	5 638	16.4
Сэтгэцийн	19 733	19.0	6 093	17.7
Хавсарсан	7 842	7.5	3 502	10.2
Бусад	31 514	30.4	11 547	33.7



Улаанбаатар хотод хөгжлийн бэрхшээлтэй 34.2 мянган хүн амьдарч байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй нийт хүн амын 33.0 хувийг эзэлж байгаа бөгөөд үлдсэн 69.3 мянга буюу 66.9 хувь нь аймаг, орон нутагт амьдарч байна.

### 3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Дэлхийн ихэнх улс орнуудын хөгжлийн бэрхшээлийн статистикийн уламжлалт чиг хандлага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог тодорхойлоход чиглэгдэж байсан бол сүүлийн үед уг ойлголт нь өргөжин, тэдгээрийн нийгмийн харилцаанд оролцоход тулгарч буй өдөр тутмын хүндрэл, бэрхшээлийг илрүүлэх, шалтгааныг нарийвчлан судлах, хэрэгцээг тодорхойлох зэрэг хөгжлийн өргөн агуулгатай болж байна. Өөрөөр хэлбэл хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь бусдын адил нийгмийн харилцаанд эрх тэгш оролцож, сайн сайхан амьдрах ёстой гэсэн үзэл санаанд үндэслэн хөгжиж байна. Үүнтэй уялдаж хөгжлийн бэрхшээлийн тоо мэдээллийг сайжруулах хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг сайжруулах ажлын хүрээнд:

- Тоо мэдээллийн нэгдмэл байдлыг хангах ажлын хүрээнд албан ёсны болон захиргааны мэдээлэл, цахим мэдээллийн сангуудын уялдааг хангах, статистикийн зорилгоор ашиглах боломжийг нэмэгдүүлэх;
- Өрхөд суурилсан түүвэр судалгаанд Вашингтон бүлгийн арга зүйг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэм, эдийн засгийн байдлын талаарх нарийвчилсан тоо мэдээллийг тооцож гаргах;
- Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүнд үндэслэн зорилтот түүвэр судалгаа зохион байгуулах хэрэгцээ байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүрээлэн буй орчинд тулгарч буй саад тотгор, бэрхшээл, түүний шалтгааныг тодруулан судлах, тоон болон чанарын судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлэн хөгжүүлж, тэдэнд чиглэсэн төрийн бодлого, хөтөлбөр, үйлчилгээг зөв оновчтой төлөвлөхөд ашиглах;
- Олон улсын ангиллыг үндэсний онцлогт нийцүүлэн нэвтрүүлэх, мөн үндэсний хэмжээнд мөрдөх ангилал, кодын хэрэгжилтийг нэмэгдүүлэх, хянах болон тоо мэдээллийн олон улсад харьцуулагдахуйц байдлыг нэмэгдүүлэх;
- Инчеоны стратегийн хэрэгжилтийг үнэлэх үзүүлэлтийн хүрээг тогтоох, тооцох;
- Тоо мэдээллийн хүртээмж, ашиглалтыг нэмэгдүүлэх буюу ялангуяа харааны бэрхшээлтэй болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх;
- Дэлхийн болон үндэсний тогтвортой хөгжлийн зорилтыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тооцох, тайлагнах;

---

<sup>2</sup> Статистикийн жилийн эмхэтгэл 2017

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хөгжил, оролцоог дэмжих эрх зүйнорчин

Энэ бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар Монгол Улсаас баримталж буй бодлого, хууль эрх зүй болон олон улсын эрх зүйн бичиг баримт, төсөл, хөтөлбөрийн талаар танилцуулж байна.

#### 1) Холбогдох хууль тогтоомж

##### 1. **Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030**

(Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан).

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчмын хүрээнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ гэж заасан.

##### 2. **Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого**

(Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолоор батлагдсан).

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын зорилго нь хүн амын тогтвортой өсөлтийг хангах, иргэдийн урт удаан, эрүүл энх, бүтээлчээр амьдрах, хөгжих таатай орчин бүрдүүлэх, хувь хүн болон гэр бүлийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

Бодлогын зорилт:

#### 4.1. “Хүн амын тогтвортой өсөлтийг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх” чиглэлээр:

4.1.14. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулж, осол, гэмтлийн улмаас нас барах явдлыг тогтвортой бууруулах, хүн амыг олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх;

4.1.15. хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх, оношлох, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны эрэлт хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлэх;

#### 4.3. “Гэр бүлийн амьдралын таатай орчныг бүрдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах”

чиглэлээр:

4.3.8. олон хүүхэдтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй болон өрх толгойлсон эцэг, эх бүхий гэр бүл, ганц бие ахмад настанд дэмжлэг үзүүлж амьдралын түвшинг дээшлүүлэх;

4.3.9. хөгжлийн бэрхшээлтэй иргэн нийгмийн үйлчилгээг хүртэх, гэр бүл, нийгмийн амьдралд идэвхтэй, тэгш оролцоход ээлтэй, хүртээмжтэй орчныг бий болгох;

4.4. “Хүн бүр боловсрол эзэмших, хөгжих боломжийг бүрдүүлэх” чиглэлээр:

4.4.5. хөгжлийн бэрхшээлтэй зэрэг тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай иргэдийн боловсролын хэрэгцээг хангах, боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах орчныг бүрдүүлэх;

4.5. “Хүн амыг ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх” чиглэлээр:

4.5.1. байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрийн чадамжид тохирсон ажлын байрыг бий болгохыг урамшуулах;

4.5.5. эмэгтэйчүүд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх талаар тусгасан байна.

### **3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн хөтөлбөр:**

1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр. Энэхүү хөтөлбөрийн “Нийгмийн бодлого” буюу гуравдугаар бүлгийн 3.3-т Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан. Үүнд:

3.3.28. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална;

3.3.29. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна;

3.3.30. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах, хөгжих үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ гэж заасан.

2. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөр” нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэх ур чадвар олгох сургалтанд хамруулах, урамшуулал, санхүүгийн дэмжлэг, хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд оршино.

3. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” 2018~2022 он: Тус үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 321 дүгээр тогтоолоор батлуулав.

### **4. Олон улсын эрх зүйн баримт бичгүүд:**

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц, НҮБ 1989 он

2. Саламанкагийн тунхаглал 1994 он

3. Дакарын үйл ажиллагааны хүрээ “Бүх нийтийн боловсролын талаар гаргасан баримт бичиг” 2000 он

4. “Биеийн үйлдэл, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн олон улсын ангилал (ICF ангилал)” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2001 он

5. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх хамтарсан бичиг баримт” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага 2004 он

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, НҮБ 2006 он

7. “Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын Удирдамж” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Хөгжил, хөгжлийн бэрхшээлийн олон

улсын консорциум 2010 он

8. НҮБ-ын 64 дүгээр ассамблейн A/RES/64/131 тогтоол
9. “Хөгжлийн бэрхшээлийн талаарх дэлхийн тайлан” Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банк 2011 он
10. Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын дэлхийн анхдугаар чуулганаас гаргасан “АГРА Тунхаглал” 2012 он
11. Ази, Номхон далайн бүсийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратеги 2012 он

## **5. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомжууд:**

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 2016 он
2. Хөдөлмөрийн тухай хууль 1999 он
3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль 2011 он
4. Нийгмийн даатгалын тухай хууль 1994 он
5. Нийгмийн халамжийн тухай хууль 2012 он
6. Боловсролын багц хууль 2002 он
7. Барилгын тухай хууль 2016 он
8. Эрүүл мэндийн тухай хууль 2011 он
9. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль 2006 он
10. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль 2015 он
11. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль 2008 он
12. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль 2006 он
13. Бусад холбогдох хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын холбогдох тогтоол, журам

## **2) Үйл ажиллагааны хэрэгжилт**

### **1. НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц**

Конвенцид нэгдэн орсноос хойш Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар:

- 2012 оны 12 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн хороонд Монгол Улсын Засгийн газар анхны тайлан илтгэлээ хүргүүлсэн.
- Монгол Улсын Засгийн газраас “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцийг 2013-2016 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн.
- 2015 оны 04 дүгээр сард НҮБ-ын Хүний эрхийн хороонд тайлан илтгэлийг Монгол Улсын Засгийн газар хэлэлцүүлсэн.
- 2019 онд Монгол Улсын Засгийн газар НҮБ-ын Хүний эрхийн хороонд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн хэрэгжилтийн 2 болон 3 дугаар тайланг нэгтгэн хүргүүлнэ.

### **3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд:**

Дараах дүрэм, журам, хөтөлбөрийг боловсруулж батлуулаад байна. Үүнд:

- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний орон тооны бус зөвлөл, аймаг дүүрэгт ажиллах салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг Засгийн газрын 2016 оны 136 дугаар тогтоолоор, Хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай бүх яамд болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дэргэд дэд зөвлөл байгуулах тухай Засгийн газрын 2017 оны 116 дугаар тогтоолоор;
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм”-ийг Засгийн газрын 2016 оны 200 дугаар тогтоолоор;
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор;
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэмлэх олгох журам, үнэмлэхийн загвар”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/109 дүгээр тушаалаар;
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх үйлчилгээний журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/184 дүгээр тоот тушаалаар;
- “Мэргэжлийн ур чадварын олон улсын тэмцээнд амжилттай оролцсон хөгжлийн бэрхшээлтэй хүнд урамшуулал олгох ба урамшуулал олгох журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/212 дугаар тушаалаар;
- “Хөтөч нохойг сургах, ашиглах журам”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А/213, А/166 дугаар хамтарсан тушаалаар;
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолоор баталлаа.
- “Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ”-ний стандарт боловсруулах салбар дундын ажлын хэсэг ажиллаж байна.

### **Хэрэгжүүлж буй төслүүд**

1. Хятадын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төв”-ийг барих төсөл /2015-2019 он/
2. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-ын “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих” төсөл /2016-2020 он/
3. Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /Жайка/-ын “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах” төсөл /2015-2019 он/ хэрэгжиж байна.

# ГУРАВДУГААР БҮЛЭГ

## Нийгмийн хамгаалал

### 1. Нийгмийн даатгал

#### 1) Холбогдох хууль тогтоомж

Нийгмийн даатгалын дараах хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын асуудлыг зохицуулж байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалын тухай хууль
2. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
3. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаасан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль
4. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль
5. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль

#### 2) Үйл ажиллагааны хэрэгжилт

Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох нь:

0-16 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс тогтооно.

Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоодог байгууллага нь Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс юм.

Аймаг, дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах орон нутгийн комисс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах төв комисс нь даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг мэргэжлийн түвшинд тогтоох үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэдэг.

Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын зорилго нь ердийн өвчин, ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас иргэн хөдөлмөрийн чадвараа бүрэн буюу хагас /хэсэгчлэн/ алдсан шалтгаан, хөдөлмөрийн чадвар алдсан хувь хэмжээ, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх, ажлын цагийг богиносгох асуудлыг магадлан шийдвэрлэх үйл ажиллагаа юм.

Комиссын бүрэлдэхүүнд аймаг, дүүргийн (2 дахь шатлал) эмнэлгийн эмч мэргэжилтэн оролцуулсан 7-9 хүнээс бүрдэх ба дотор, мэдрэл, мэс заслын эмч, нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмч, нийгмийн даатгалын хэлтсийн магадлагч эмч, нийгмийн даатгалын хэлтсийн ажилтан, нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, ажил олгогчийн төлөөлөл, даатгуулагч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөөс бүрдэнэ.

Харин төв комиссын бүрэлдэхүүнд нийгмийн даатгалын байгууллагын магадлагч эмч, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн салбар зөвлөлийн шинжээч эмч нар, ажил олгогчийн төлөөлөл 15 хүнтэй байна.

2015 онд Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комисс нь анх удаа хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг эмхэтгэн гаргасан ба 2017 онд даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах өвчний жагсаалт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацааг шинэчлэн батлах тухай А/39, А/12 дугаар тушаал шинээр батлагдсан ба эмнэлэг,

хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг нэмж эмхэтгэн гаргасан. Иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг бүрэн алдсан буюу 70-аас дээш хувь, хагас алдсан буюу 50-69 хувиар алдсан гэж 2 ангилдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай хуульд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс”-ийг батлуулахаар тусгаснаар 2014 оны 01 дүгээр сард төв комисс, аймаг, дүүрэгт орон нутгийн комисс байгуулагдаж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт оношилгоо төдийгүй хөгжүүлэн засах хөгжлийн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлж байна.

Монгол Улсын төрөөс нийгмийн хамгааллын асуудлыг онцгойлон анхаарч, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа боловч нийгмийн хамгаалал, халамж анхаарал шаардаж буй хүн амын тодорхой хэсэг болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо төдийлөн буурахгүй байна.

2016 онд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч иргэн 112023 байгаа нь нийт хүн амын 3,6 хувийг эзэлж байна. Үүнээс сэтгэцийн эмгэг, мэдрэлийн өвчин, ахуйн осол, цусны эргэлтийн системийн өвчин, нүдний өвчин нь хөдөлмөрийн чадвар алдалтын тэргүүлэх шалтгаан болж байгаа ба нийт хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн 60 хувийг эзэлж байна.

### **Нийгмийн даатгалын үйлчилгээний төрөл:**

Даатгуулагчид үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээг дараах даатгалын төрлөөс олгож байна. Үүнд:

- Тэтгэврийн даатгал
- Тэтгэмжийн даатгал
- Ажилгүйдлийн даатгал
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал
- Эрүүл мэндийн даатгал

### **1. Өндөр насны тэтгэвэр:**

Даатгуулагч нь нийтдээ 20 буюу түүнээс дээш жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 60 нас хүрсэн (эмэгтэй 55) өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрхтэй.

#### Тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл (тооцох аргачлал)

Даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн сарын дундаж цалингийн 45 хувиар өндөр насны тэтгэврийг тогтооно. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд 1.5 хувиар, сар тутамд 0.125 хувиар бодож нэмэгдэл олгоно.

#### Хувь тэнцүүлсэн тэтгэвэр

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-20 хүртэлх 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгоно.

#### Хөнгөлөлттэй нөхцөл

- Төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан, дөрөв түүнээс дээш хүүхдээ 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн, 50 нас хүрсэн бол өөрийн хүсэлтээр тэтгэвэр тогтоолгон авна.

- Газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагч хуульд заасан болзол хангасан тохиолдолд эрэгтэй 50, 55, эмэгтэй 45 нас хүрээд тэтгэвэр тогтоолгон авна

**Тайлбар:** 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн өндөр насны тэтгэврийн нас жил бүр 6 сараар нэмэгдэнэ.

60 нас хүрээд өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргах даатгуулагчийн шимтгэл төлсөн байвал зохих хугацаа (20 жил) 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс жил бүр 3 сараар нэмэгдэнэ.

## **2.Тахир дутуугийн тэтгэвэр**

Энэ нь тэтгэврийн даатгалын нэг төрөл буюу Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоолгосон даатгуулагч иргэд тахир дутуугийн тэтгэвэр авах эрхтэй байна.

“Тахир дутуугийн тэтгэвэр” гэдэг нь ажил хөдөлмөр эрхлэн шимтгэл төлж, ажиллаж байгаад хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон даатгуулагч иргэнд өнгөрсөн хөдөлмөрийн үйл ажиллагаанаас хамааралтайгаар авч байсан цалин, хөдөлмөрийн хөлснөөс тооцож зориулалтын сангаас түүний хөдөлмөрийн чадваргүй байгаа хугацаанд буюу хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл амьжиргааны эх үүсвэр болгон сар бүр олгож байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ.

### Тахир дутуугийн бүрэн тэтгэвэр тогтоолгох эрх

- Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар байнга буюу удаан хугацаагаар хөдөлмөрийн чадвар алдсан;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20-иос доошгүй жил төлсөн;
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нийтдээ 20 жил төлөөгүй даатгуулагчийн хувьд тахир дутуугийн бүрэн тэтгэвэр тогтоолгоход харгалзах нэг гол болзол бол хөдөлмөрийн чадвар алдахын өмнөх 5 жилийн дотор нийтдээ 36 сар буюу 3 жилд заавал шимтгэл төлсөн байна.

### Тахир дутуугийн тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгох эрх

- Ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа 50-иас доошгүй хувиар тогтоолгосон байх;
- Нийтдээ 3-20 хүртэл жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байх.

### Тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт материал

Бүрдүүлэх материал:

- Нийгмийн даатгалын дэвтэр;
- 1995 оноос өмнөх хугацаанд ажиллаж байсан бол хөдөлмөрийн дэвтэр;
- Хугацаат цэргийн алба хаасан бол цэргийн батлах, эсхүл архивын лавлагаа;
- 1995 оноос өмнөх 5 жилийн цалин хөлсийг сонгосон тохиолдолд батлагдсан маягтын дагуу тухайн ажиллаж байсан аж ахуйн нэгж байгууллагаар, эсхүл архивын сан хөмрөгөөс гаргуулсан лавлагаа;
- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;



- Тэтгэвэр тогтоолгохыг хүссэн өргөдөл;
- Иргэний үнэмлэх;
- 2 хувь цээж зураг /3\*4 хэмжээтэй/

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгон тэтгэвэр авч буй иргэн ажил, хөдөлмөр эрхэлж байгаа бол авч буй сарын цалин, хөлснөөсөө тооцуулж нийгмийн даатгалын шимтгэлийг албан журмаар төлдөг бол тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийн хувьд сайн дураараа нийгмийн даатгалын шимтгэл төлөх эрх нь нээлттэй юм. Сайн дураараа тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхдөө сарын орлогоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, шимтгэл төлөх сарын дээд хэмжээнээс ихгүй байхаар өөрөө тодорхойлно. Ийнхүү хуульд заагдсан өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас болон шимтгэл төлсөн байвал зохих хугацааны болзлыг хангасан тохиолдолд нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр тогтоолгож болно. Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд нь 1 хувиар бодож нэмэгдүүлнэ.

### **3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйлчилгээ**

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан хугацааг харгалзахгүйгээр тахир дутуугийн тэтгэврийг дундаж сарын хөдөлмөрийн хөлс, орлогоос даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээгээр тогтоож олгоно.

Мөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагч нь рашаан сувилалд сувилуулсан тохиолдолд сувиллын зардал, ирж очих унааны зардлыг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллагаас жилд нэг удаа хариуцан төлнө.

### **4. Ажилгүйдлийн тэтгэмж:**

Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг ажлаас чөлөөлсөн тухай тушаал шийдвэр гарснаас өмнө 24 сараас доошгүй хугацаанд, үүнээс сүүлийн 9 сард нь тасралтгүй төлснөөр эрх үүснэ. Ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээ нь сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна.

Уг тэтгэмжийг даатгуулагч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын хэлтэст бүртгүүлсний дараагийн өдрөөс эхлэн ажлын 76 өдрөөр тооцож олгоно.

### **5. Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж:**

Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж: Тэтгэмжийн даатгалын шимтгэлийг ердийн өвчин, ахуйн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдахаас өмнө 3 ба түүнээс дээш сарын хугацаагаар төлсөн даатгуулагчид хамаарна. Ажил олгогч болон Эрүүл мэнд, нийгмийн даатгалын байгууллага нь даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг ажлын өдрөөр тооцож 50, 55, 75 хувиар тооцож олгоно. Даатгуулагчийн хөдөлмөрийн чадвараа түр хугацаагаар алдсан ажлын эхний 5 өдрийн тэтгэмжийг ажил олгогчоос, 6 дахь өдрөөс эхлэн хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх, эсвэл хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх үүсэх хүртэл хугацаанд ажлын 66 өдрийн, хуанлийн жилд удаа дараа өвдөл ажлын 132 өдрийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллага олгоно.

### **3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ**

Хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлж халдварт бус өвчин, ахуйн ослыг бууруулж, хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, эрт илрүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвар алдсан даатгуулагч /иргэн/-ий эрүүл мэндийн байдлыг тогтмол хянах, эмчлэн эрүүлжүүлэх, сэргээн засах тусламж, үйлчилгээний нэр төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар нийгмийн бүхий л түвшинд тэдний оролцоог нэмэгдүүлж, боловсрол эзэмшүүлж, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.

## **2. Нийгмийн халамж:**

### **1) Холбогдох хууль тогтоомж**

1. Нийгмийн халамжийн тухай хууль
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль
3. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль
4. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль /2018.01.01-ний өдрөөс эхлэн хэрэгжинэ/

### **2) Нийгмийн халамжийн чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ**

#### **А. Тэтгэвэр, тэтгэмж**

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу дараах тэтгэвэр, тэтгэмжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн авах эрхтэй.

#### *Нийгмийн халамжийн тэтгэвэр*

Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1-д “Нийгмийн халамжийн тэтгэвэр /цаашид “тэтгэвэр” гэх/-ийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй дараах иргэнд сар бүр олгоно” гэж заасны дагуу

- Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- 16 насанд хүрсэн одой иргэд үүнд хамрагдаж байна.

Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 2013 онд 103,600 төгрөг байсан бол 2014 онд 115,000 төгрөг, 2015 онд 126.500 төгрөг, 2016 онд 140,000 төгрөг болгон нэмэгдүүлсэн байна.

#### *Нийгмийн халамжийн тэтгэмж*

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1-д заасан Нийгмийн халамжийн тэтгэмж /цаашид “тэтгэмж” гэх/ -ийг дараах төрөлд хөгжлийн бэрхшээлтэй хүн авах боломжтой.

#### *Асаргааны тэтгэмж*

- Тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа;
- Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа;

### Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж

- Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхдэд Засгийн газраас тогтоосон тухайн үеийн нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээний тусламжийг /сар бүр 140,00 төгрөг/
- Байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн /улирал бүр 60,000 төгрөг/

### **Б. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн халамжийн үйлчилгээ**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн дагуу дараах тусламж, хөнгөлөлтийг эдлэх эрхтэй.

#### Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан 9 төрлийн үйлчилгээний хамрагдах зорилтот бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж байна.

#### Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасан төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд харж хандах хүнгүй, бие даан амьдрах чадваргүй, асаргаа сувилгаа зайлшгүй шаардлагатай ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулан байршуулж, хооллон, асаргаа сувилгаа, нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлж байна.

#### Нийгмийн хөгжлийн үйлчилгээ

1. Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ /нийгмийн халамжийн дэмжлэг, тусалцаа зайлшгүй шаардлагатай өрх иргэн/
2. Боловсролыг дэмжих үйлчилгээ /сурах бичгийг үнэ төлбөргүй олгох/
3. Эрүүл мэндийг дэмжих үйлчилгээ /Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах/

Дээрх 3 төрлийн үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг.

#### Хөнгөлөлт, тусламж

1/ байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, бүрэн хараагүй, бүрэн хэлгүй, дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

2/ 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезын үнийг эдэлгээний хугацаа дууссан болон тухайн хүүхдийн өсөлтийн улмаас бие эрхтэнд нь таарахгүй болсон тохиолдолд тухай бүр 100 хувь нөхөн олгох;

3/ үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг гурван жил тутам нэг удаа нөхөн олгох;

4/ 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг гурван жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох;

5/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн цэцэрлэг, сургуульд ирж, очих унааны зардлыг хөнгөлөх, эсхүл автобусаар үйлчлэх;

6/ насанд хүрсэн бүрэн хараагүй, сонсголгүй, хэл ярианы бэрхшээлтэй хүний харилцаа холбооны зардалд хөнгөлөлт үзүүлэх;

7/ дотоодын рашаан сувилалд сувилуулах шаардлагатай дараах хүнд ирж, очих унааны, ор хоногийн зардлыг эрүүл мэндийн даатгалтай иргэний энгийн өрөөний тарифаар тус тус тооцон доор дурдсан хувиар жилд нэг удаа нөхөн олгох:

- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 100 хувь;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асран халамжилж яваа нэг иргэнд 50 хувь;
- үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 50 хувь.

8/ бүрэн хараагүй хүн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр эмчлүүлэх, рашаан сувилалд сувилуулахаар аймгаас нийслэлд, нийслэлээс аймагт зорчсон тохиолдолд ирж, буцах унааны зардлын 75 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

9/ нийслэлээс 1000 ба түүнээс дээш километр алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох;

10/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүний нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;

11/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нь хүүхдийн зусланд амарвал эрхийн бичгийн 50 хувийг жилд нэг удаа олгох;

12/ хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эмнэлгийн магадлагаагаар дотоодод усан эмчилгээ хийлгэсэн бол эмчилгээний төлбөрийн 70 хувийг нөхөн олгох;

13/ хараагүй хүний брайлийн үсгээр бичсэн захидал, ил захидал, брайль хэвлэл, 10 кг хүртэлх илгээмжийг дотоодод үнэ төлбөргүй явуулж, хараагүй хүний зориулалттай техник, тоног төхөөрөмж, материал хэрэгслийг дотоодод үнэ төлбөргүй хүргүүлэх;

14/ нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нас барвал түүний оршуулгын зардалд нийгмийн даатгалын сангаас олгох оршуулгын тэтгэмжтэй тэнцүү хэмжээний мөнгөн тусламж олгох;

15/ аарцаг эрхтэний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэх.

16/ хөгжлийн бэрхшээлтэй хүнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулах;

17/ Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэн болон тэдгээрийг асран хамгаалагчийг нийгмийн халамжийн үйлчилгээ, тусламжид хамруулах;

18/ хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих хөнгөлөлт эдлэх.

### 3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

- Нийгмийн халамжийн тухай багц хуулийн шинэчлэлтэй холбогдуудан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, түүнийг дагаж гарах журамд өөрчлөлт оруулах;
- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулж батлуулан мөрдөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасан аарцаг эрхтний үйл ажиллагаа алдагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүнд эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр зайлшгүй шаардлагатай асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материалын дэмжлэг үзүүлэхэд шаардагдах төсөв хөрөнгийн тооцоо судалгааг хийж төсөвт тусгуулах;

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

## Хөдөлмөр эрхлэлт

### 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

#### 1) Холбогдох хууль тогтоомж

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэргэжлийн нөхөн сэргээлт, хөдөлмөр эрхлэлтийн тухай 159 дугаар конвенцид<sup>3</sup> хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олох, ажлын байраа хадгалах, ахиж дэвших адил боломж олгох, тэгш хандах, тухайн ажил нь өөрийн сонголтод нийцэж, хувь хүний боломж чадварыг харгалзсан байх зэрэг нийтлэг хэм хэмжээг заасан байдаг.

Түүнчлэн тус конвенцид мэргэжлийн нөхөн сэргээлтэд хамруулах, хөдөлмөрийн зах зээлд нээлттэй оролцуулах, хөдөлмөр эрхлэлт, нөхөн сэргээлтийн дэд бүтцийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын цагийг богиносгох, тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг татвар, бусад төлбөрөөс чөлөөлөх, мэдээлэл хүргэх, тэднийг дэмжихэд чиглэсэн орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, багш нарыг бэлтгэх, давтан сургах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг гишүүн орнуудад зөвлөсөн.

Конвенцийн дагуу Монгол Улсын Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг эдлүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид тусгасан. Тухайлбал:

- Хөдөлмөрийн тухай хуульд 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах, мөн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны ажлын цагийг богиносгох, ээлжийн амралтыг уртасгах, аж ахуйн нэгжид хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулах квот тогтоох, биелүүлээгүй тохиолдолд торгууль төлбөр ногдуулах;
- Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулинд монгол иргэдийг авч ажиллуулж буй гадаад орны аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулах гэрээний үндсэн нөхцөлд Монгол Улсын иргэн гадаад улсад хөдөлмөр эрхэлж байхдаа хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн буюу бүрэн алдсан тохиолдолд ажил олгогчоос ажилтанд олгох төлбөр, тэтгэмж, нөхөн төлбөрийн хэмжээг тусгах заалтыг шинээр нэмж оруулсан нь гадаадад ажиллаж буй монгол иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах боломжийг дээшлүүлэх;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулинд 25-аас дээш ажиллагчидтай аж ахуйн нэгжийн нийт ажиллагсдын 2/3 ба түүнээс дээш хувийг хараагүй ажилтан эзэлдэг бол уг аж ахуйн нэгжийг орлогыг албан татвараас чөлөөлөх, 50-иас дээш хувиар хөдөлмөрийн чадвараа алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаг аж ахуйн нэгжид нийт ажиллагчдад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эзэлж байгаа хувь хэмжээгээр тооцон албан татварын хөнгөлөлт үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор аж ахуйн нэгж, иргэнээс хандивласан нэг сая хүртэлх хэмжээний төгрөгийн хандивыг тухайн татварын жилд уг аж ахуйн нэгжийн албан татвар ногдох орлогоос хасч тооцож байх;
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулинд хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд өөрт нь болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар

<sup>3</sup> Монгол Улс 1998.02.03-нд соёрхон баталсан.

хангасан ажил олгогчид санхүүгийн тусламж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулахаар тус тус тусгасан байдаг.

Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр заалтын дагуу төлбөрийн хэмжээг Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 26 дугаар тогтоолоор баталсан.

**Аж ахуйн нэгж, байгууллагаас хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулаагүй орон тоо тутамд сар бүр төлөх төлбөрийн хэмжээ**

№	Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын тоо	50 хүртэлх ажиллагчтай	51-ээс дээш ажиллагчтай
1	Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймаг	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 40 хувиар	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувиар
2	Бусад аймаг		Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 30 хувиар

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 111.6-д “Аж ахуйн нэгж, байгууллага тогтоосон төлбөрийг 24 сар тасралтгүй төлсөн тохиолдолд дараагийн 12 сард ногдох төлбөрийг чөлөөлнө” /Энэ хэсгийг 2008 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуулиар нэмсэн/ гэж зохицуулсан. Энэхүү төлбөр нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрдөг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд зориулсан төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулагдаж байгаа нийт хөрөнгийн 20 орчим хувийг бүрдүүлдэг.

**2) Үйл ажиллагааны хэрэгжилт**

Үндэсний статистикийн хорооны 2017 оны мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй хөдөлмөрийн насны **19974** хүн хөдөлмөр эрхэлж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй тэтгэврийн насны хүн **3018** байгаа юм. Хөдөлмөр эрхэлдэггүй хөгжлийн бэрхшээлтэй хүн **73285** байна.

“Ажил эрхэлдэг” хэмээн бүртгэгдсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажил эрхлэлтийн статусаар нь судлахад 41.7 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 35.7 хувь нь цалин хөлстэй ажиллагч, 20.1 хувь өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч, 1.6 хувь нь ажил олгогч, 0.3 хувь нь нөхөрлөл, хоршооны гишүүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь төсвийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагад буюу албан хэвшилд гэрээ байгуулан ажиллах боломж харьцангуй хязгаарлагдмал, эсрэгээр албан бус хэвшилд ажиллах эсвэл цалин хөлсгүйгээр өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд оролцох байдал харьцангуй илүү байна.

2017 оны 10 дугаар сарын байдлаар Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд шалгалт хийжээ. Шалгалтанд 636 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан байна. Эдгээрээс 192 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулаагүй, ажлын байрны төлбөрийг төлөөгүй байна. Улсын байцаагчийн 116 акт үйлдэж 348 сая төгрөгийн нөхөн төлбөр тавьснаас 97 байгууллагад 277 сая төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн санд төвлөрүүлсэн байна. Мөн 125 аж ахуйн нэгж, байгууллагад 25.4 сая төгрөгийн захиргааны хариуцлага ногдуулж, 100 аж ахуйн нэгжид 6 заалт бүхий улсын ахлах байцаагчийн зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйл түүнтэй нийцүүлэн гаргасан тогтоол шийдвэр, дүрэм журмын хэрэгжилтийн байдалд улсын хэмжээнд шалгалт хийсэн бөгөөд 11 дүгээр 25-ны дотор нэгтгэн дүнг танилцуулна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулаагүйн төлбөр нь төсвийн болон төрийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн төсөв төлөвлөгөөнд тусгагдаагүй байдаг нь ажил олгогчдод торгууль оногдуулахад хүндрэлтэй асуудал болдог.

### Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр

Д/д	Арга хэмжээ	2017 оны гүйцэтгэл		
		Хүн	Хөрөнгө	Хувь
1.	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	672	44,362.0	81%
2.	Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	171	7,020.0	13%
3.	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	898	2,053,310.0	98%
4.	Борлуулалтын дэмжлэг	515	93,914.5	50%
5.	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт		67,542.0	68%
6.	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	2729	57,657.5	69%
7.	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт	584	144,636.0	83%
8.	Ажил олгогчийн урамшуулал	213	81,792.0	36%
9.	Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох		677,530.0	60%
	<b>Дүн</b>	<b>5782</b>	<b>3,227,764.0</b>	<b>78%</b>

### 3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах хийхээр ажлын хэсэг үзэл баримтлалын төслийг боловсруулаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль нь 2001 онд анх батлагдаж, 2011 онд шинэчилсэн найруулга хийгдсэн бөгөөд шинэчилсэн найруулга батлагдсанаас хойш уг хуульд нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байжээ. Гэвч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зарим арга хэмжээ, үйлчилгээг агуулгын хувьд бага зэрэг өөрчилсөн 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хуулиас бусад тохиолдолд Төсвийн тухай болон бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулж, мөн хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг, хөдөлмөр эрхлэлтийн удирдлагын тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбогдуулан тус тус нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байдаг.

Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хамрах хүрээ, төрөл, хэлбэр, тэдгээрийн



дагуу хэрэгжүүлэх үйлчилгээ, арга хэмжээ, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын болон бүртгэл, мэдээллийн тогтолцоо, санхүүжилтийн механизм (Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан), хуулийн харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхой тусган зохицуулалтыг хийсэн боловч улс орны өнөөгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас улбаалж тус хуульд шинэчлэл, өөрчлөлт хийх зайлшгүй шаардлага бий болж байна.

Тогтвортой хөгжлийн зорилго 8 буюу “Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих”-д 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох зорилтыг дэвшүүлсэн.

Энэхүү зорилтыг хангах чиглэлээр Үндэсний статистикийн хороо нь улирал тутам явуулдаг ажиллах хүчний судалгааны түүврийн дизайн, асуулгын бүтцийг өөрчилж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажилгүйдлийн түвшин, дундаж цагийн хөлсний статистик мэдээллийг бий болгохоор ажиллаж байгаа болно.

## **2. Мэргэжлийн боловсрол, сургалт**

Монгол Улсын хэмжээнд 83 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж, үүнээс төрийн өмчийн 50, төрийн бус өмчийн 33 байна.

2017-2018 оны хичээлийн жилд 35831 суралцагч суралцаж байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй суралцагч 673, үүнээс эмэгтэй суралцагч 352 байна.

Хөгжлийн бэрхшээлийн ангиллаар авч үзвэл харааны бэрхшээлтэй 223 суралцагч байгаа бөгөөд үүнээс эмэгтэй 119 суралцагч, ярианы бэрхшээлтэй 79, үүнээс эмэгтэй 42 суралцагч, сонсголын бэрхшээлтэй 111, үүнээс эмэгтэй 55 суралцагч, хөдөлгөөний бэрхшээлтэй 116, үүнээс эмэгтэй 63 суралцагч, сэтгэцийн бэрхшээлтэй 58, үүнээс эмэгтэй 33 суралцагч, бусад төрлийн бэрхшээлтэй суралцагч 86 байна.

### **1) Холбогдох хууль тогтоомж**

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль
2. Боловсролын тухай хууль
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

#### **Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хүрээнд:**

Энэ хуулийн хүрээнд мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилго, бүтэц, түүний удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг тусгасан байна. Тус мэргэжлийн боловсрол, сургалтын бүтэц, бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсрол, сургалтын төвүүд хамаарна. Хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулна.

#### **Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр**

Монгол Улсын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, иргэдийн хэрэгцээ, авъяас, сонирхолд тохирсон мэргэжлийн болон техникийн боловсролыг шинэчлэн хөгжүүлж, чанар, хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлэхэд хөтөлбөр чиглэж байгаа.

Энэхүү хөтөлбөрт мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын шинэчлэлийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийн бодит

механизм бүрдүүлж төлөвшүүлэх, үйлдвэрлэлийн хөгжлийн хэрэгцээтэй холбож төрөлжүүлэх, мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх, багш нарыг заах арга зүй болон мэргэшсэн инженер, техникийн ажилтны түвшинд чадваржуулах, сургалтын нөхцөлийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, иргэдийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгасан.

Хөтөлбөрийн 4.4.4 дүгээр заалтад хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэсэгт “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг мэргэжлийн боловсрол, сургалтад тэгш хамруулах боломжийг нэмэгдүүлэх” талаар мөн тусгасан байна.

Тус хөтөлбөрт 2019 онд хэрэгжилтийн дунд хугацааны зорилтот түвшинд, 2021 онд зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөсөн.

## **2) Үйл ажиллагааны хэрэгжилт**

Төрийн өмчийн болон төрийн бус өмчийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн танилцуулга:

### *Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв*

Тус төв нь үндэсний хэмжээнд хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх, хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн боловсрол олгох сургалт явуулах, эрүүл мэндийн тусламж үзүүлэх, сэргээн засах хэрэгсэл, хиймэл эрхтэн үйлдвэрлэх зэрэг сэргээн засалтын тусламж, үйлчилгээг цогцоор нь чанартай, хүртээмжтэй хүргэх үүрэг бүхий байгууллага юм.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн баримжаа олгох сургалтыг тус төвийн нэгж Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль эрхлэн явуулдаг. Тус сургууль нь 15-45 насны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг 1-2,5 жилийн мэргэжлийн ангид суралцуулах боломжтой ба бусад мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдээс ялгаатай нь боловсролын түвшин хамаарахгүй сургуулиас завсардсан болон суурь боловсролгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мэргэжлийн боловсрол, чиг баримжаа олгож байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлийн боловсрол олгож, тэдэнд харилцаа, амьдрах ухаан, бизнес аж ахуй эрхлэх, англи хэл, биеийн тамир, эрүүл мэндийн болон мэргэжлийн технологийн хичээлүүдийг /20 хувь/ онол, /80 хувь/ дадлага хослуулан заадаг.

Үүнд: Нэг жилийн Тогооч, Талх, нарийн боов үйлдвэрлэлийн технологийн ажилтан, Оёмол бүтээгдэхүүний оёдолчин /2,5 жил/, Модон эдлэлийн мужаан, Бэлэг дурсгалын зүйл урлаач, Хэвлэлийн дизайнч /2,5 жил/, Гар утас, телефон аппаратны засварчин гэсэн 7 чиглэлээр мэргэжлийн боловсрол олгох сургалтуудыг явуулж байна.

### Сургалтын орчин нөхцөл



Нийт 20-25 хүний багтаамжтай дотуур байртай, жилд 90-120 хүртлэх 16-45 нас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн авах чадалтай.

Анги дүүргэлт 8-12 /20%-д энгийн иргэдийг суралцуулдаг/. Суралцах хугацаа 1-2,5 жил байна.

Нэг сар хүртэлх богино хугацааны ур чадвар олгох сургалтыг Нийслэл, дүүрэг, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдтэй хамтран явуулдаг.

Мөн сонсголын бэрхшээлтэй иргэдтэй хамтран ажиллаж, төрийн болон төрийн бус байгууллагуудад дохионы анхан шатны/ багш, нийгмийн ажилтнуудад/ болон хэлмэрч, орчуулагчийн сургалтыг зохион байгуулдаг.

### СЗСҮТ-ийн дотуур байр



Мэргэжлийн боловсрол, ур чадвар олгох сургууль нь сургуулийн эрхлэгч 1, сургалтын менежер 1, хөдөлмөр зуучлал хариуцсан мэргэжилтэн 1, мэргэжлийн технологийн 9 багш, дохионы хэлмэрч орчуулагч 1, номын санч 1, ерөнхий эрдмийн 4 багш нийт 18 багш, ажилтантайгаар сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Тус төвд 4 жилийн байдлаар нийт **335** хөгжлийн бэрхшээлтэй иргэн мэргэжлийн баримжаа олгох сургалтуудад хамрагдсан байна.

#### *МБУЧОС-д 2014-2017 онд суралцсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл*

№	Хичээлийн жил	Суралцагчдын тоо
1	2014-	85
2	2015-2016	65
3	2016-2017	69
4	2017-2018	11
	Нийт	<b>335</b>

#### *2017-2018 оны хичээлийн жилд суралцагчдын мэдээ*

№	Мэргэжлийн чиглэл	Суралцагчдын тоо
<b>1 жилийн анги</b>		
1	Гар утас, телефон аппаратны засварчин	12
2	Бэлэг дурсгалын зүйл урлаач	12
3	Модон эдлэлийн мужаан	12
4	Талх, нарийн боов үйлдвэрлэлийн технологийн ажилтан	12
5	Тогооч	12
<b>2.5 жилийн анги</b>		
1	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин А	12
2	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин Б	11
3	Хэвлэлийн график дизайны анги А	12
4	Хэвлэлийн график дизайны анги Б	10
5	Хэвлэлийн график дизайны анги В	11
<b>Суралцагчдын нийт тоо</b>		<b>116</b>

#### *Хараагүй иргэдийн холбооны мэргэжлийн сургалтын төв*

2016 оны 07 дугаар сарын байдлаар тус төв нь массаж, морин хуур, компьютер, ноос ноолуур боловсруулах гэсэн 4 чиглэлээр 2 жилийн хугацаатай сургалт явуулдаг. Мөн донор

байгууллагын санхүүгийн дэмжлэгтэйгээр хөдөө орон нутгийн хараагүй иргэдэд зориулсан, таягтай алхах сургалт, мөн сургагч багш бэлтгэх сургалт явуулдаг.

Япон улсад дадлага эзэмшсэн 10 гаруй багш массажны сургалт явуулж байна. Мөн орон нутгаас ирсэн дадлагажигч нарт зориулсан 14 хүний ортой дотуур байртай (улсын төсвөөр баригдсан). Байр жилдээ 70-80 хүн хүлээж авах хүчин чадалтай.



*Алхах сургалт*



*Массажны өрөө*

### Бусад мэргэжлийн сургалтын төв

Монголд ажилгүй иргэдэд зориулсан сургалтаас гадна хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт ч бий. Ийм арга хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцоход нэг хүнийн сургалтын төлбөрийг 130000 төгрөгөөр тооцож, дээр нь 30 хувийн нэмэгдлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас сургалт зохион байгуулагчид төлдөг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагууд ч өөрсдөө ийм сургалт зохион байгуулдаг. Үүнд “БИТ” төрийн бус байгууллагаас эрх мэдэлжүүлэх сургалт, хувийн аж ахуйн нэгжүүдэд зориулсан ажил эрхлэлт дэмжих сургалт, нийгмийн ухамсрыг шинэчлэх сургалт зэргийг зохион байгуулж байна. Эдгээр сургалтыг зохион байгуулдаг 70 гаруй

байгууллага байдаг ба жилдээ 7000-8000 хүн хамрагддагаас 100 орчим нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг. 2014 оноос зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дадлагажих сургалт зохион байгуулж байна. Мөн Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвтэй хамтран арга хэмжээ зохион байгуулж байна.

### **3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ**

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого, Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээнүүдийн дагуу Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв нь дараах үйл ажиллагаануудыг мэргэжлийн боловсрол, сургалтын чиглэлээр хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

- Сургалтанд ашиглагдаж буй ном сурах бичгийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй хэлбэрээр сайжруулах /аудио, видео, DVD, брайль, дүрс зурган өгүүлэмжтэй/;
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын “Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээл, сэргээн засал судлал, тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлыг судалж, мэдээллийн сан үүсгэх;

- Их, дээд сургуулиудад хөгжлийн бэрхшээлийн талаар нөлөөллийн сургалт зохион байгуулах;
- Төвийн бүсийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах сургалтын чиглэлээр сургалт зохион байгуулах;
- Сургалтын төлөвлөгөөний дагуу “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр”-ийг сургуулийн онцлогт нийцүүлэн сайжруулан боловсруулах;
- Төгсөгчдийн “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийн үйл ажиллагааг сайжруулах;

## ТАВДУГААР БҮЛЭГ

### Эрүүл мэнд

#### 1) Холбогдох хууль тогтоомж

Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан.

Бодлогын баримт бичгийн гол зорилго нь хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, үйлчлүүлэгчээ дагасан зохистой санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан дундаж наслалтыг уртасгахад орших юм.

#### Эрүүл мэндийн тухай хууль

Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, иргэний эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхийг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэний гүйцэтгэх үүрэг, эрүүл мэндийн байгууллага, ажилтны үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль

Энэ хуулийн зорилт нь хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах, удирдах, санхүүжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль

Энэ хуулийн зорилт нь хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх талаар төрөөс баримтлах бодлого, зарчмыг тодорхойлох, сэтгэцийн эмгэгтэй хүний эрхийг хамгаалах, нийгэм, эдийн засгийн харилцаанд оролцох, бие даасан байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, сэтгэл зүйн тусламж авах нөхцөлийг хангахад иргэн, хуулийн этгээдийн хүлээх үүрэг, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг байгууллага, эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги

Эрүүл мэндийн сайдын 2011 оны 228 дугаар тушаалаар батлагдан 2011-2015 онд хэрэгжсэн. Энэхүү тушаалын зорилго нь хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тулгуурлан сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, дэмжих, амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

#### Дүлийрэлт, сонсгол бууралтаас сэргийлэх, хянах үндэсний стратеги (2010-2019)

I үе шат: 2010- 2014

II үе шат: 2015-2019

Зорилго: Хүн амын дүлийрэлт, сонсгол бууралтын түвшинг тогтоон 2019 онд тогтоосон түвшингээс 5 хувиар бууруулах

Стратегийн зорилт: 1. Дүлийрэлт, сонсгол бууралт, тэдгээрт хүргэдэг хүчин зүйлсийн тархалтыг тогтоож, эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч сонсгол хамгаалах үйл ажиллагааг дэмжинэ.

2. Эрүүл мэндийн тусламжийн бүх шатлалд чих, сонсголын тусламж, үйлчилгээг найдвартай үзүүлэх сүлжээг бий болгож, дүлийрэлт сонсгол бууралтыг эрт оношлох, эмчлэх, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулж байгаа бүх хэлбэрийн мэргэжлийн байгууллагуудын чадавхийг сайжруулна.

Сэргээн засах тусламж, үйлчилгээний журам (ЭМС-ын сайдын 2015 оны 487 дугаар тушаал)

Уг журмаар Эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын уялдаа холбоог зохицуулах, мэргэжилтнийг арга зүйгээр удирдах, сэргээн засах тусламж, үйлчилгээний тогтвортой байдлыг хангах, бие махбодь, сэтгэцийн үйл ажиллагааны алдагдал, нийгмийн оролцооны хязгаарлагдмал байдлыг бууруулах, арилгахад чиглэсэн эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн олон талт үйл ажиллагааг зохицуулсан.

“Сэтгэцийн эрүүл мэнд” үндэсний хоёр дахь хөтөлбөр (2010-2019)

I үе шат: 2010-2014

II үе шат: 2015-2019

Хөтөлбөрийн зорилго нь хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны болон нийгэм, хамт олонд тулгуурласан тусламж, үйлчилгээг өргөжүүлэх замаар сэтгэц, зан үйлийн эмгэгийн тархалтыг бууруулах нөхцөл бүрдүүлэхэд оршино.

“Амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр (2014-2021)

I үе шат: 2014-2017 он

II үе шат: 2017-2021 он

Хувь хүн, гэр бүл, байгууллага хамт олонд эрүүл аж төрөх дадал, зан үйлийг төлөвшүүлэх, амьдралын буруу хэвшлээс үүдэлтэй зонхилон тохиолддог халдварт бус өвчний хяналт, тандалт, менежментийг сайжруулах замаар урьдчилан сэргийлэх боломжтой халдварт бус өвчний өвчлөл, чадвар алдалт, цаг бусын эндэгдлийг бууруулах орчин бүрдүүлэхэд энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр (2010-2016)

I үе шат: 2010-2012

II үе шат: 2013-2016

Хөтөлбөрийн зорилго нь осол гэмтэл, хүчирхийлэлд хүргэж байгаа эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, түүнээс сэргийлэх, осол гэмтлийн үед үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан олон улсын жишигт ойртуулах замаар осол гэмтэл, хүчирхийллийн сөрөг үр дагаврыг багасгахад оршино.

## **2) Үйл ажиллагааны хэрэгжилт**

Сэргээн засалт

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгмийн идэвхтэй харилцаанд оруулж, нийгмийн идэвхтэй гишүүн болоход сэргээн засалт маш чухал байр суурь эзэлдэг.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтоор /ДЭМБ/ “Хүний чадвар алдалтыг бууруулж, нийгмийн хэвийн харилцаанд оруулах зорилгоор хийж буй бүхий л



аргыг сэргээн засалт” гэнэ. Энэ тодорхойлолт нь эмнэлзүйн сэргээн засах эмчилгээтэй хамааралтай боловч гол нь чадвар алдалттай хүмүүст шаардлагатай байдаг нийгмийн таатай орчинг бүрдүүлж, нийгмийн сөрөг нөлөөлөл, саадыг багасгахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

### Хамт олонд түшиглэсэн сэргээн засалт

1978 онд “2000 он гэхэд бүх нийтээрээ эрүүл байх” Алма-Атагийн тунхаглал гарч, нарийн мэргэжлийн эмнэлгийн сэргээн засах тусламж, үйлчилгээ хязгаарлагдмал байгааг харгалзан ДЭМБ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанарыг хамт олны санаачилгаар дамжуулан сайжруулахад чиглэгдсэн Хамт олонд түшиглэн сэргээн засах /ХОТСЗ/ хандлагыг танилцуулсан юм.

2004 онд Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО), ДЭМБ-аас “Хамт олонд түшиглэн сэргээн засах, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх стратеги”-ийн хамтарсан баримт бичгийг баталсан.

2010 онд ДЭМБ-аас дэлхий нийтээр дагаж мөрдөх ХОТСЗ-ын стратегийг хэрэгжүүлэх Удирдамжийг боловсруулан гаргасан. 2017 онд уг удирдамжийг Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв “АИФО” Италийн ТББ, “Дэлхийн Зөн Монгол” төслийн техникийн болон санхүүгийн дэмжлэгтэйгээр ДЭМБ-ын албан ёсны зөвшөөрөлтэйгээр монгол жишээтэй хэвлэн гаргасан.

ХОТСЗ хандлагын удирдамжийг 30 гаруй жилийн хугацаанд дэлхийн 90 гаруй орон хэрэгжүүлж байгаа бөгөөд үүний нэг нь Монгол Улс юм.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж Эрүүл мэндийн сайдын тушаалаар жил бүрийн 12 дугаар сарыг "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийг дэмжих сар" болгон сарын турш хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахтай холбоотой учирч байгаа саад бэрхшээлийг багасгахад чиглэсэн арга хэмжээг бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд зохион байгуулж ирсэн. Дээрх ажлын хүрээнд:

- Эмнэлгүүдийн угтах үйлчилгээний ажилтнуудыг дохионы хэлний анхан шатны сургалтад хамруулсан.
- Дүүрэг, нэгдсэн эмнэлгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх зорилготой “Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн бичилтэд хяналт тавьж, эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх өдөрлөг зохион байгуулах, харьяаллын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гэрээр сэтгэл зүйн зөвлөгөө өгч шаардлагатай иргэдийг гуравдугаар шатлалын эмнэлгийн тусламжинд хамруулах;
- Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, нэмэгдүүлэх, нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах, сургалт зохион байгуулах;
- Эрүүл мэндийн бүх шатны байгууллагуудын эмч, эмнэлгийн ажилтнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тэдэнд хандах эерэг хандлагыг бий болгох;
- Эмнэлгийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангах, хүртээмжтэй орчныг бий болгох чиглэлээр ажиллаж байна.

### **3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд 2018-2022 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийн нэгдүгээр зорилт буюу “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрүүл мэндийг боломжит дээд хэмжээнд хүргэх” зорилтын хүрээнд үйл ажиллагааг төлөвлөн ажиллан

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ

### Боловсрол

#### 1) Холбогдох хууль тогтоомж

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын сурч боловсрох эрх зүйн орчин

#### Нэг. Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого
3. Боловсролын тухай хууль
4. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
5. Бага, дунд боловсролын тухай хууль
6. Дээд боловсролын тухай хууль
7. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

#### Хоёр. Монгол Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоол

1. Монгол Улсын Их Хурлын 2013 оны 19 дүгээр тогтоол
2. Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоол
3. Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоол
4. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоол
5. Засгийн газрын 2017 оны 162 дугаар тогтоол
6. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 46 дугаар тогтоол
7. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 24 дүгээр тогтоол

#### Гурав. Сайдын тушаал

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Тусгай цэцэрлэг, сургуулийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/195 дугаар тушаал
2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/196 дугаар тушаал

Боловсролын тухай багц хуулийн 2013, 2016 оны нэмэлт өөрчлөлтөөр дор дурдсан асуудлууд шинээр тусгагдсан.

- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлэхээр болсон.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч ажиллахаар болсон.
- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагын харьяанд шилжихээр болсон.
- Ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч тусгай мэргэжлийн багш, туслах багш, сэтгэл зүйч, сувилагч, сэргээн засалч, нийгмийн ажилтан ажиллуулж болно гэсэн.

- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь сэргээн засалтын кабинет, танхимтай байна.

Монгол Улсын Их Хурлын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах чиглэлээр мэргэших дохионы хэлний багш, арга зүйч, эмч, согог зүйч зэргийг бэлтгэх зорилгоор нийт 20-иос доошгүй хүнийг жил бүр гэрээгээр, сургалтын төрийн сангийн зардлаар гадаадад сургахаар шийдвэрлэсэн.

Монгол Улсын Засгийн газрын “Журам батлах тухай” 2012 оны 185 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй 1 суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлсэн бөгөөд энэ заалт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургаж байгаа ердийн цэцэрлэг, сургуульд нэгэн адил хамаарч байна.

Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ыг баталсан бөгөөд тус журмын 4.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын сурацлагч”, 4.1.3-т “хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг олгоно” гэсний дагуу улсын төсвөөс хариуцаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн “Сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг шинэчлэн батлах тухай” А/311 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар “Оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”, тавдугаар хавсралтаар “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”, зургаадугаар хавсралтаар “Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”-г тус тус баталсан.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 46 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг хэрэгжүүлэх хүрээнд ерөнхий боловсролын тусгай сургуулийн багш, холбогдох зарим байгууллагын удирдах ажилтанд зориулсан “Япон улсад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах сургалт”-ыг 2017 оны 11 дүгээр сарын 13-20-ны өдрүүдэд зохион байгууллаа. Тус сургалтад оролцогчид нь Япон улсын боловсролын бодлого, хэрэгжилтийн тухай сургалтад хамрагдахаас гадна Япон улсын Кита дүүргийн тусгай хэрэгцээт боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцана.

Ийнхүү ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцагч хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн харилцан ялгаатай хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрч, тэдний сурч боловсрох эрхийг нь дэмжин ажиллаж байна.

## 2) Үйл ажиллагааны хэрэгжилт

### А. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сурах үйл явцыг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй 1599 хүүхэд цэцэрлэгт, 7279 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байна. Ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1637 нь ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцаж байна.

#### Ерөнхий боловсролын тусгай сургуулийн суралцагчид үдийн хоолтой боллоо.



Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 162 дугаар тогтоолоор тусгай сургуульд суралцагчийн үдийн хоолны зардлыг 2400 төгрөг болгон баталснаар 2017-2018 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын тусгай сургуулийн 1-12-р ангийн суралцагчид анх удаагаа үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж эхлээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид үдийн хоолны үйлчилгээнд хамрагдсанаар хоногт авбал зохих хоол хүнсний хэрэгцээний 40-45 хувийг үдийн хоолоор авч чадах боломж бүрдсэнээр эдгээр хүүхдийн эрүүл мэндийн хөгжил болон суралцахад нь чухал дэмжлэг болсон. Үдийн хоолоор үйлчлэх орчин нөхцөлийг сайжруулах үүднээс ерөнхий боловсролын тусгай 6 сургуульд улсын төсвийн санхүүжилтээр гал тогооны тоног төхөөрөмжийг нь шинэчилсэн.



#### Сурах бичгийн шинэчлэл хийж, сургалтын хэрэглэгдэхүүнтэй болголоо

Энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын тусгай сургуулийн бага ангийн 4 нэр төрлийн сурах бичгийг 175 сая төгрөгийн санхүүжилтээр улсын төсвөөс хэвлэн, түгээлээ. Үүнд.



1. Дүрслэх урлаг, технологи I-V /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын/
2. Математик IV /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын/
3. Монгол хэл V /Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын/
4. Монгол хэл V /Сонсголын бэрхшээлтэй сурагчдын/

“Монгол хэлний тухай” хуулийг хэрэгжүүлэх хүрээнд сургуулийн өмнөх насны сонсголгүй хүүхдэд зориулсан анхан шатны хэрэглээний 1000 үг бүхий “Дохионы хэлний зурагт толь бичиг”-ийг НҮБ-ын хүүхдийн сангийн 24,5 сая төгрөгийн санхүүжилтээр 1000 хувь хэвлүүлсэн.

## **Б. Сургуульд хамрагдахгүй байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ**

2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 26 насан туршийн боловсролын төв, 326 нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрт нийт 9291 хүүхэд суралцаж байгаагийн 18,5 хувь буюу 1716 нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Тэдний 30,9 хувь нь оюун ухааны бэрхшээлтэй, 4,5 хувь нь хавсарсан хэлбэрийн бэрхшээлтэй суралцагчид байна. Тэдний 39,8 хувь буюу 683 нь бага боловсрол, 41,6 хувь буюу 714 суурь боловсрол, 18,6 хувь буюу 319 нь бүрэн дунд боловсрол эзэмших түвшний ангид суралцаж байна.

Хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх ажлыг Насан туршийн боловсролын үндэсний төвтэй хамтран Нийслэлийн Баянзүрх дүүргийн 4 хорооны хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол эзэмших хэрэгцээний судалгааг авч, 8 хүүхдийг гэрээр сургах ажлыг эхлүүллээ.

## **В. Тусгай хэрэгцээт боловсролын багшлах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ**

Монгол Улсын Боловсролын их сургуулийн Боловсрол судлалын төвийн дэргэд Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх (D40300 индекстэй) 1 жилийн бакалаврын хөрвөх сургалтыг 2 ангитайгаар 2013 оны 10 дугаар сараас анх удаа нээн хичээллүүлсэн. Дээрх мэргэжлээр 2013-2014 оны хичээлийн жилд 46, 2014-2015 оны хичээлийн жилд 31, нийт 77 оюутан төгсөж тусгай сургууль, цэцэрлэг, төрийн бус байгууллагуудад мэргэжлийн чиглэлийн дагуу ажиллаж байна.

Бакалаврын 1 жилийн хөрвөх сургалтын хөтөлбөрийг 2015-2016 оны хичээлийн жилээс өргөжүүлэн 3,5 жилийн бакалаврын сургалт болгосон. Одоогийн байдлаар 1, 2, 3-р курсэд нийт 58 оюутан суралцаж байна.

Монгол Улсын Боловсролын их сургуулийн нэг жилийн хөрвөх сургалтад хамрагдаж буй ерөнхий боловсролын тусгай сургуулийн 16 багшид сургалтын тэтгэлэг олгосон. Мөн Хөвсгөл аймгийн тусгай хэрэгцээт боловсролын бүлэг хичээллүүлж байгаа болон хүүхэд хөгжлийн төвтэй ердийн хэв шинж бүхий ерөнхий боловсролын сургуулийн 14 багшийг тусгай хэрэгцээт боловсролын сургалт арга зүйн сургалтад хамруулсан.

Тусгай хэрэгцээт боловсролын багшийн мэргэжлийн 3,4-р курсийн оюутнуудын сонгон судалдаг “Дохионы хэл” хичээлийн хөтөлбөр, агуулгыг сайжруулах ажлыг “Дохионы хэлний орчуулагч хэлмэрчдийн холбоо”-той хамтран хийсэн.

Жайка байгууллагын “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд төсөлд оролцож байгаа тусгай 4 сургууль, мөн Хөвсгөл аймгийн туршилтын ерөнхий боловсролын 2 сургуулийн төлөөлөл бүхий 8 хүнийг 2018 оны 01 дүгээр сард Япон улсад зохион байгуулагдах сургалтад хамруулна.

## **Г. Сургалтын орчинг сайжруулан дэмжих чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Дэлхийн банкны “Боловсролын чанарын шинэчлэл”-ийн төслөөс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын тусгай хэрэглэгдэхүүний чанарыг сайжруулахад 303 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

ЖАЙКА “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-өөс тусгай хэрэгцээт боловсролыг дэмжих төрөл бүрийн аргыг туршин хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн “Бичил төсөл”-ийн сонгон шалгаруулалтад Монгол Улсын Боловсролын их сургуулийн харьяа 249-р цэцэрлэг, Ховд аймгийн Жаргалант сумын ерөнхий боловсролын 7 дугаар сургууль, “Сонсголгүйн боловсрол” нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага тус тус шалгарч, тус бүр 12,0 сая төгрөгийн санхүүжилт авсан.

Ерөнхий боловсролын тусгай 29 дүгээр сургуулийн камерийн хяналтын систем, гэрэлтүүлгийг хийхэд шаардагдах 80,0 сая төгрөгийн санхүүжилтийг Азийн хөгжлийн банкнаас авахаар болсон.

### **3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ**

Ерөнхий боловсролын тусгай 6 сургуульд зайлшгүй шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн жагсаалтыг гаргаж, холбогдох 2,1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг боловсролын салбарын 2018 оны тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хөрөнгө оруулалтын төсөвт тусгууллаа. Тус хөрөнгө оруулалтын хүрээнд ерөнхий боловсролын тусгай сургууль тус бүрт 1 автобус шинээр олгоно. Мөн ерөнхий боловсролын тусгай сургуулийн эм бэлдмэл, хичээл үйлдвэрлэлийн санхүүжилтийг өмнөх оныхоос 2 дахин орчим нэмэгдүүлж 412.6 сая төгрөг болгосон.

Ерөнхий боловсролын тусгай сургуулийн сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээ, сургалтын төлөвлөгөөг суралцагчдыг бие дааж амьдрах, суралцах арга чадварт сургах, ахуйн баримжаатай болгох, тэдний биеийн хөгжлийн үйл явцыг нөхөн сэргээх, засан сайжруулах, мөн мэргэжлийн сургалт, чадамжийн гэрчилгээ олгодог сонголттой, уян хатан сургалтын зохион байгуулалтад шилжүүлэх чиглэлээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Тэгш хамруулан суралцуулах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Япон олон улсын хамтын ажиллагааны Жайка байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд тусгай 4 сургууль болон ердийн хэв шинж бүхий 6 ерөнхий боловсролын сургууль дээр туршсан “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний загвар болон ашиглах гарын авлага”-ыг боловсруулаад байна.

# ДОЛООДУГААР БҮЛЭГ

## Хүртээмж

### 1. Дэд бүтцийн хүртээмж

#### 1.1 Барилга байгууламж

##### 1) Холбогдох хууль тогтоомж

“Хот байгуулалтын тухай хууль”-ийн 20 дугаар зүйлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн талаар тусгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн саадгүй үйлчлүүлэх орчин нөхцөлийг хангаагүй хот төлөвлөлт, барилгажилтын шийдэл, зураг төсөл зэрэгт зөвшөөрөл олгохыг хориглосон байдаг.

Мөн Барилгын тухай хууль /шинэчилсэн найруулга/-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шаардлага”-ыг 15 дугаар зүйлд тусган хэрэгжүүлж байна. “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай” MNS 91.040.10: 2009 стандарт, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг тооцсон төлөвлөлт”, “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон зайн төлөвлөлт” барилгын дүрэм, “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт” барилгын норм ба дүрэм, “Сургалт хүмүүжлийн барилгын зураг төсөл зохиох” заавар, “Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулахын барилгын технологийн зураг төсөл” барилгын дүрэм, “Үр тариа хадгалах болон боловсруулах байгууламж” барилгын норм ба дүрэм, “Үйлдвэрийн газрын байгууламж” барилгын норм ба дүрэм зэрэг 10 гаруй норм ба дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагын талаар тусган мөрдүүлж байна.

“Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” (БНБД 30.01.04)-ийг шинэчлэх ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн дэд бүтцийн байгууламжуудад саадгүй хүрэх нөхцөлийг хангахтай холбогдсон хот төлөвлөлтийн стандарт шаардлагуудыг тусган боловсруулж байна.

##### 2) Үйл ажиллагааны хэрэгжилт

Засгийн газрын 2017 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн дагуу “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллийг орууллаа. Дээрх стандартуудыг хангуулж ажиллахаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, дэд бүтцийн хүртээмжийг бий болгох тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар албан даалгаврыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, “Барилгын хөгжлийн төв” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, “Төрийн орон сууцны корпораци” Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт өгсөн.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, дэд бүтцийн хүртээмжийг бий болгох тухай” Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 02 дугаар албан даалгавраар нийслэл, аймаг, орон нутагт байгаа нийтийн зориулалттай барилга байгууламжуудын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй эсэхэд орон нутгийн захиргаатай хамтран үзлэг хийж, судалгаа гарган, хүртээмжтэй болгох чиглэлээр бодлого боловсруулж 2017 онд багтаан танилцуулах ажлыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт үүрэг өгсөн болно. Дээрх албан даалгаврын дагуу Ховд, Дорноговь, Дорнод зэрэг аймагт дэд бүтцийн хүртээмжтэй эсэхэд орон нутгийн захиргаатай хамтарсан үзлэг шалгалтыг хийж холбогдох зөвлөгөөг өгч ажилласан.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, дэд бүтцийн хүртээмжийг бий болгох ажлын хүрээнд барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж ажиллах хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөллүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж сургалтыг 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан.

Монголын Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо дэд бүтцийн хүртээмжийн үнэлгээний хуудас боловсруулан (хаалга, налуу шат, үүдний хүлээн авах хэсгийн тавцангийн өндөр, угтах үйлчилгээ байгаа эсэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан автомашины зогсоол гэх мэт олон талаас нь үнэлэх) Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисстой хамтран нийт 28 байгууламжид үнэлгээ хийсэн байна. Үүний үр дүнд Гадаад харилцааны яам хүртээмжтэй орчныг бүрдүүлэх арга хэмжээ авсан.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг стандартын дагуу бий болгох ажлын хүрээнд жилд 2 удаа зохион байгуулагддаг “Архитекторын мэргэшсэн зэрэг горилогчдод зориулсан сургалт”-ын хөтөлбөрт дээрх чиглэлээр 2-4 цагийн хичээл тусгуулан зураг төсөл зохиогчдод энэ талын зохих мэдлэг олгож байна. Мөн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Барилга, архитектурын сургуулийн сургалтын хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг норм, стандартын дагуу бий болгох талаар тусган оюутнуудад мэдлэг олгож байна. Мөн Монголын Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны гишүүн нь Барилгын хөгжлийн төвийн инженерүүдэд багшлан сургалт явуулсан (Хоёр дахь жилдээ хэрэгжиж байгаа). Мөн шинээр баригдаж буй нисэх онгоцны буудлыг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй болгоход ч тус яамнаас зөвлөмж өгсөн.

Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 57 дугаар тушаалаар “Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөл”-ийг байгуулан, ажиллах журмыг батлуулан ажиллаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөлөл болох Монголын Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо төрийн бус байгууллагын тэргүүн Б.Чулуундолгорыг Барилга, хот байгуулалтын сайдын зөвлөлийн бүрэлдэхүүнд дахин шинээр оруулсан.

### **3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ**

- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэмд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангасан арга хэмжээг тусган боловсронгуй болгох ажлын техникийн даалгаврын төслийг боловсруулах, холбогдох байгууллагуудтай хамтран уулзалт, хэлэлцүүлэг хийх;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангасан арга хэмжээг “Барилгын норм, норматив боловсруулах сангийн хөрөнгөөр 2018 онд боловсруулах норм, норматив, дүрэм, заавар, төсөл, арга хэмжээний төлөвлөгөө”-ний төсөлд тусгуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн дэд бүтцийн байгууламжид саадгүй хүрэх нөхцөлийг хангах талаар хот, суурины хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын зураг төсөл, барилга байгууламжийн зургийн даалгаварт тусгуулах;
- Магадлал хийлгэхээр ирүүлсэн барилга байгууламжийн зураг төсөлд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм” БД 31-112-11, “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн гарын авлага” БД 31-101-04-д заасан шаардлагыг хангах арга хэмжээг тусгасан эсэхэд магадлал хийж хэрэгжилтийг хангах;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламжийн техник хяналтыг зураг төсөлд заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангах арга хэмжээг хангуулан ажиллах;

- Нийтийн зориулалттай барилга байгууламжийг холбогдох стандартын дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох ажлыг зохион байгуулах ажлыг эхлүүлэх;

## **1.2 Авто зам, явган хүний зам**

### **1) Холбогдох хууль тогтоомж**

Улаанбаатар хотын авто зам нь Нийслэлийн Засаг даргын эзэмшилд байдаг бөгөөд Нийслэлийн Авто замын хөгжлийн газар нь авто зам, замын байгууламжийн засвар арчлалтыг хариуцан ашиглалтын бэлэн байдлыг хангадаг. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллаганы хөтөлбөрийн 3.3.28-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална”, 3.3.29-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна.” гэж тус тус заажээ.

Авто зам болон явган хүний замын стандарт нь дараах байдалтай байна:

- “Нийтийн тээвэр Замналын зогсоол. Ангилал. Техникийн шаардлага” MNS 5879- 2012
- “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам.Техникийн шаардлага” MNS 5682:2006
- “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009
- Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага” MNS 6055:2009
- “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолын төлөвлөлт” БД 32-101-17

“Автотээврийн тухай хууль”-ийн 10.2.8-д “20-иос дээш тооны тээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж нь тээврийн хэрэгслийнхээ 10 хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай төхөөрөмж суурилуулсан байх” талаар заажээ. Заасан хувь хэмжээнд хүргээгүй тохиолдолд торгууль ноогдуулна гэсэн заалттай ч торгуулийн хэмжээг заагаагүй байна.

### **2) Үйл ажиллагааны хэрэгжилт**


Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам Улаанбаатар хотын 19-р хорооллын явган замд тактель зам шинээр хийсэн.

“Түгээмэл хөгжил” бие даан амьдрах төвийн санаачилгаар Улаанбаатар хотод 20 ширхэг гишгүүргүй автобус үйлчилгээнд явж байна. Тус төв 2014 онд нийтийн тээврийн хэрэгслийн хууль эрх зүйн баримт бичиг, автобус, авто зогсоолын талаар мониторинг судалгаа хийсэн. Одоо аж ахуйн нэгж, албан байгууллагуудад таниулга, сургалт явуулж байгаа. Улаанбаатар хотод тэргэнцэртэй иргэдэд зориулсан тусгай такси таван ширхэг явж байна.

Монголын Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооноос Зам, тээврийн хөгжлийн яаманд санал гаргаснаар Монголын гол төмөр замын галт тэрэгний буудал, олон улсын нисэх онгоцны буудалд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай хүлээлгийн өрөө, бие засах газар бий болгов. «SOS үйлчилгээ» хэмээх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан хүмүүст зориулсан үйлчилгээ (машины зогсоолд орж гарах г.м) нэвтрүүлсэн. Одоогийн байдлаар төмөр замын дотоодын чиглэлд унтдаг ор бүхий хоёр вагоныг тэргэнцэртэй иргэн ашиглаж болохуйцаар төхөөрөмжилжээ.

“Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн замын даргын 2015 оны 12 дугаар сарын 31-ний “Зорчигчийн вагон өөрчлөн тоноглох тухай” А-331 тоот тушаалаар Зорчигчийн вагон депогийн засварын тасгийн хамт олон MNS 5876:201, “Төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ, зорчигчийн галт тэрэг, вагоны үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага”, MNS 6312:2012, “Төмөр замын зорчигчийн вагон. Техникийн ерөнхий шаардлага”, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орон зай, орчны зураг төсөл зохиох дүрэм зэргийг үндэслэн 482-р вагоныг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан шинэчлэн тоногосон. Зорчигчийн вагоныг өөрчлөн орон зайг томсгон, дохиолол дуудлагын хонх, өргөсгөсөн тавцан, тавиур, угаалтуур, тусгай зориулалтын шат болон тусгай төхөөрөмжөөр тоногосноор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тэргэнцэртэйгээ төмөр замаар хүндрэл чирэгдэлгүй, ая тухтай аялуулах боломжийг бүрэн бүрдүүлсэн.

“SOS” үйлчилгээний ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тав тухтай аялах боломжийг бий болгох зорилгоор өөрчлөн тоногосон 482-р вагоныг 2016 оны 05-р сарын 02-ны өдрөөс эхлэн Замын–Үүд, Эрдэнэт, Сүхбаатарын чиглэлд аялуулж байна.



*Хөгжлийн бэрхшээлтэй зорчигчид зориулсан вагоны дотоод бүтэц,*



*482-р вагоны дотоод тоноглол*



*482-р вагонд хөгжлийн бэрхшээлтэй зорчигчдыг суулгах шат, ариун цэврийн өрөө*



*Хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэргэнцэртэй зорчих тавцан*

SOS үйлчилгээ нэвтрүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, нэмэлт үйлчилгээг нэвтрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх зам, үйлчилгээний цонхыг нээн ажиллуулж байна.



*УБ төмөр замын буудал  
“SOS үйлчилгээ”*



*Хүртээмжтэй болгосон галт тэрэ*

### 3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ

#### Нэг. Салбар хоорондын үялдаа холбоотой хийгдэх ажлууд:

- Зам, тээврийн хөгжлийн яамнаас боловсруулж байгаа хууль тогтоомжийн стандарт, норм нормативт хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байх заалтуудыг заавал оруулах, шалгуур үзүүлэлт болгон тодорхойлох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгаа, үнэлгээ хийлгэж дүгнэлт гаргуулах;
- Нийтийн тээвэр болон төмөр замын авто вокзалуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй жишиг вокзал болгож засварлахад шаардлагатай төсвийн тооцоог гаргаж, улсын төсөвт болон бусад төсөл хөтөлбөрт суулгуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;
- Нийтийн тээвэр болон төмөр замын авто вокзалуудыг /Амгалан өртөө, Толгойт өртөө, Драгон авто вокзал, Баянзүрхийн авто вокзал/ хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй жишиг вокзал болгож засварлах;

#### Хоёр. Төмөр замын үйлчилгээнд:

- "Төрөөс төмөр замын салбарт баримтлах бодлого"-д нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах заалтыг тусгуулах;
- Нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи, үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах чиглэлээр сургалт зохион байгуулж сургалтын мөрөөр хэрэгжүүлэх үр дүн, гарсан өөрчлөлтийн талаарх хэлэлцүүлэг зохион байгуулах;
- Улаанбаатар хотын вокзалын нүхэн гарцанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу зам болон лифтийг бий болгох;

#### Гурав. Агаарын тээврийн үйлчилгээнд:

- "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-д нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах заалтыг тусгуулах;
- Хөшигийн хөндийн шинэ нисэх буудал дээр зохион байгуулсан үзүүлэх сургуулилтын мөрөөр хийгдсэн ажлын мэдээллийг салбар зөвлөл дээр сонсох;
- SOS үйлчилгээний хүрээнд батлагдсан "Тусламж шаардлагатай зорчигчдод үйлчлэх" журмыг үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлж, хэвшүүлэх;
- Олон улс, орон нутгийн чиглэлийн нислэгийн бүртгэлийн 2 цэгийн тавцанг намсгаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэхэд зориулан засварлах;

#### Дөрөв. Авто тээврийн үйлчилгээнд:

- "Автотээврийн тухай хууль"-д нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах заалтыг тусгуулж хэрэгжилтийг хангаж ажиллах;
- Нийтийн тээврийн хэрэгслийн буудал, зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах;
- Нийтийн тээврийн хэрэгслээр зорчих хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зорилгоор холбогдох стандартыг шинэчлэн тогтоож, сайжруулах;
- Авто вокзалын болон тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх чиглэлээр сургалт

зохион байгуулж, гарын авлага, зөвлөмжөөр хангах;

Тав. Авто замын салбарт:

- Авто зам, замын байгууламжийн зураг төслийг төлөвлөхдөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэх, тэднийг тээврийн салбарын үйлчилгээнд тэгш хамруулах нөхцөлийг бүрдүүлсэн байдлыг тооцох, энэ тал дээр зураг төслийн байгууллагуудад чиглэл өгч ажиллах;
- Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага MNS 5682:2009 стандартуудыг шинэчлэн боловсруулах саналыг яаманд хүргүүлж, төлөвлөгөөнд тусгуулах;
- Одоо мөрдөгдөж байгаа стандарт норм, нормативыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн заалтуудыг судлах, судалгааны үндсэн дээр орчин үеийн зам, замын байгууламжийн төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан төлөвлөлтийг хийх;
- Улаанбаатар хотын авто замын явган хүний гарцад харааны бэрхшээлтэй хүнд зориулсан дуут дохиолол суурилуулах;

## **2. Мэдээллийн хүртээмж**

### **1) Холбогдох хууль тогтоомж**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд "Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ шаардлагад нийцүүлэх" гэсэн асуудлын хүрээнд төрийн байгууллагын цахим хуудсыг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх, дэлгэц уншигч програм хангамж болон шинэ технологи, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлэх, сонин сэтгүүл, төрийн байгууллагын шийдвэр, албан бичиг, барааны шошго зэргийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй ашиглахад зориулан бар кодтой хэвлэх, сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессэж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэхээр туссан.

Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлогын Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээний төрөл, хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний талаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа хэсгийн 3.4.5-д "хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ" гэсэн заалтыг тусгасан.

Мөн Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 281 дүгээр тогтоолын 28 дугаар зүйлд сонсголын бэрхшээлтэй иргэд нь олон нийтийн мэдээллийг урсдаг титр, дохионы орчуулгын тусламжтай хүлээн авах эрхтэй, мэдээллийн хэрэгслийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор дохионы орчуулга, урсдаг титрийг тогтмолжуулах заалтууд оржээ.

### **2) Үйл ажиллагааны хэрэгжилт**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 136, 2017 оны 116 дугаар тогтоолын дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг салбарын хэмжээнд уялдуулан зохицуулж, удирдамж чиглэл өгөх зорилгоор Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/91 тоот тушаалаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийг төр, хувийн хэвшил болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан байгуулж, ажиллаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл нэгтгэн боловсруулах төв, Монголын Улсын Сонсголгүй иргэдийн үндэсний холбоо хамтран 2015 оны 05 дугаар сарын 20-ны өдөр баталсан санамж бичгийн дагуу 2015 оноос сонсголын бэрхшээлтэй иргэдийн яаралтай дуудлагыг (Гал түймэр 101, цагдаа 102 г.м) өдөр бүр 24 цагийн турш мессэжээр хүлээн авч байна. Одоогоор сонсголын бэрхшээлтэй 7 иргэнээс 63 удаа дуудлага хүлээн авч, мессэж илгээж асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн Финландын донор байгууллагын дэмжлэгээр дохионы хэлний хэлмэрч бэлтгэх сургалтад тус төвийн 22 ажилтныг хамруулаад байна.

Монгол Улсын Их сургуулиас NVDA дэлгэц уншигч програм дээр ашиглах боломжтой 1500 өрүүлбэрээс бүтсэн эмэгтэй хоолой, 3000 өгүүлбэрээс бүтсэн эрэгтэй хоолойн SAPI5 монгол бичвэрийг ярианд хөрвүүлэх програм хангамжийг зохион хөгжүүлсэн бөгөөд цаашид энгийн хүний яриатай адилхан болгох, гадаад үгийн дуудлагыг сайжруулах ажлыг хийх шаардлагатай байна.

Харилцаа холбооны тухай хуулийн 25.2.1-д "тусгай зөвшөөрлийн хүрээнд хэрэглэгчийг ялгаварлахгүйгээр үйлчилгээгээр шуурхай хангах", Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 11.4-т "Сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессэж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг төрөөс бүрдүүлнэ" гэсэн заалтын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы "Миний туслах 104" үйлчилгээг гаргасан. Тусгай дугаар ашиглалтад орсноор сонсголын бэрхшээлтэй иргэн видео дуудлага хийж дохионы хэлний хэлмэрчтэй холбогдсоноор үйлчилгээ авах боломж бүрдэнэ.

### **3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн хурлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх заалтын хүрээнд 2017-2025 онд дараах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

- Компьютерын дэлгэц дээрх бичгэн мэдээллийг дуу авиа руу хөрвүүлэн хувиргах програм хангамжийг монгол хэл дээр боловсруулах;
- Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй тоног төхөөрөмж болон олон нийтэд хүртээмжтэй цахим хуудасны стандарт боловсруулах;
- Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийг аудио тайлбар, дохионы хэл дээр хөрвүүлэн гаргах;
- Монгол хэл дээр дэлгэц уншигч, өнгө, дүрс, дулаан, гэрэл, мөнгө таних тусгай хэрэгцээт програм хангамжийг хөгжүүлэх;
- Засгийн газрын болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн цахим хуудсыг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох;
- Банкны АТМ, ТҮЦ машиныг хөгжлийн бэрхшээлтэй хүн ашиглах боломжтой болгох; (брайль тэмдэг, аудио тайлбартай болгох)

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### Бусад

#### 1) Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах

##### 1) Олон улсын хэмжээнд дагаж мөрдөх баримт бичиг

Гамшгийн эрсдэлийг бууруулах дэлхийн гуравдугаар бага хурал Япон улсын Мияаги мужийн Сендай хотноо 2015 оны 03 дугаар сард зохион байгуулагдсан. “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд авч хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийг баталж, долоон зорилтыг дэвшүүлж, үйл ажиллагааны 4 тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үүнд:

1. Гамшгийн эрсдэлийг ойлгох;
2. Гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх;
3. Гамшигтай тэмцэх чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хөрөнгө оруулах;
4. Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх үе шатанд “Сайжруулан барьж байгуулах” үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

Гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд нас, хүйс, хөгжлийн бэрхшээлээр ангилсан мэдээлэл, уламжлалт мэдлэгээр баяжуулсан хүртээмжтэй, шинэчлэгдсэн, өргөн хүрээтэй, шинжлэх ухаанд суурилсан, нийтэд зориулсан мэдээллийг нээлттэй солилцох, түгээх талаар шийдвэр гаргах шаардлагатай байдаг гэж тус баримт бичигт заасныг “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэх Азийн төлөвлөгөө”-д түүнийг тусгасан билээ.

Монгол Улс нь Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг, нийгмийн комиссын гишүүн орны нэг бөгөөд Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийн 10 зорилгын “Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах, менежментийг баталгаажуулах» гэсэн 7 дахь зорилт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлд хамаарсан томоохон эрх зүйн баримт бичиг болно.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх зүйн орчин а) Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 36 дугаар зүйл. Онцгой байдлын үед авах арга хэмжээний 36.1-д "Хүний амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, нийтийн эмх замбараагүй байдал, дайн бүхий байдал зэрэг онцгой байдал бий болох үед хөгжлийн бэрхшээлтэй хүнд энэ тухай хүртээмжтэйгээр мэдээлэх, тухайн үед амь нас, эрүүл мэндийг нь онцгой байдлын нөхцөлтэй уялдуулан хамгаалах үүргийг төрийн холбогдох байгууллага хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ", 11.4-д "Сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессэж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг төрөөс бүрдүүлнэ" гэж тус тус заасан байна.



б) 2015 оны 07 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын 303 тоот тогтоолоор “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр” батлагдсан. Энэ хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. 3.2.3-д "гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгийг олон нийтэд олгох, эрсдэлгүй зан үйлийг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг иргэд, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, өндөр настан, амьжиргааны түвшин доогуур орлоготой иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тохирсон арга барилаар зохион байгуулах", 3.2.4-д "олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан, хүүхэд, сайн дурынхан, залуучуудад зориулсан ном, гарын авлага, заавар, сэрэмжлүүлэг, дүрс бичлэгийн богино хэмжээний кино хийх, үзүүлэн таниулах болон тараах материал бэлтгэж нийтэд түгээх" гэж тус тус заагдсан байна.

в) НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах байгууллагаас жил бүрийн 10 дугаар сарын 13-ны өдрийг Олон улсын гамшгийн эрсдэлийг бууруулах өдөр болгон зарлаж гишүүн улс, орон бүр тодорхой уриан дор дараа жилийн 10 дугаар сарын 13-ны өдрийг хүртэл тодорхой ажлыг зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлдэг.

2013-2014 оны Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрсдэлийг бууруулах” уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн.

## **2) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гамшгаас хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ**

### Сургалт сурталчилгааны ажил

Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдрийг тэмдэглэх ажлын хүрээнд 21 аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, орон нутаг дахь олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран иргэдийн гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлаа хангахад нь мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, нийт 94911 иргэн, 75999 сурагчдад 82 цагийн гамшгаас хамгаалах танхимын сургалт, 17 цагийн дадлага сургуулилт, 14 цагийн үзүүлэх сургууль зохион байгуулж, 1086 хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулав.

2014 онд “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгээр “11В5”, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз, ТВ-9 телевизүүдээр 14 хоногт 1 удаа 20 минутаар, давталттайгаар дараах нэвтрүүлгүүдийг гаргасан. Үүнд: Нийслэлийн Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран:

- “Амилуулах суурь тусламж” ярилцлага
- Тархины цус харвалт, зүрхний шигдээсийн үед иргэд өөртөө болон бусдад үзүүлэх тусламж
- Бэртэж гэмтсэн тохиолдолд үзүүлэх анхны тусламж
- Ясны хугарлын үед үзүүлэх тусламж
- Хахах үед үзүүлэх анхны тусламж зэрэг цуврал хичээлүүдийг багтаасан CD-г хэвлүүлэн сургалт, сурталчилгаанд ашиглаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг боловсрол

олгох зорилгоор Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны харьяа Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвтэй /хуучнаар/ хамтран дээрх ТВ сургалтуудыг дохионы хэлний орчуулгатайгаар хүргэсэн.

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэрийн төвийн 120 иргэнийг газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх дадлага сургуульд хамруулсан.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлага олгох нь” сэдэвт сургалтыг Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвд зохион байгуулав.

- Монголын Дүлий иргэдийн нийгэмлэг
- Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо
- Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо
- Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн үндэсний төв
- Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийн багш ажилчид
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрчний эвлэлийн холбоо
- Монголын Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо зэрэг байгууллагуудын нийт 60 гаруй иргэн хамрагдсан.

2014 онд Онцгой байдлын ерөнхий газар, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны оролцоотойгоор “Гамшгийн эрсдэлийг бууруулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлагдан хэрэгжсэн.

2014 оны 11 дүгээр сард хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тусгай сургуулийн сурагч, хүүхдүүдэд гамшиг ослын талаарх мэдлэг олгох, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио хүргэх, дохиогоор ажиллах дадлагыг нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Онцгой байдлын газраас Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо, Сургалт арга зүйн төв, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажилладаг байгууллага, суралцдаг сургууль болох эсгийний үйлдвэр, цаасан уутны үйлдвэр, мужааны цех, хэвлэх үйлдвэр, 25, 29, 70 дугаар тусгай сургуулийн 309 ажилтан, 53 багш, 269 хүүхэд нийт 631 хүн оролцуулан гамшгаас урьдчилан сэргийлэх танхимын сургалт явуулж, гамшгийн үед аюулгүй зай талбайд гарах дадлагыг зохион байгуулсан.

2016 онд Нийслэлийн Онцгой байдлын газраас Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо, Монголын Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Монгол Улсын Сонсголгүй иргэдийн үндэсний холбоотой хамтран аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын үед хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хэрхэн харьцах, аврах үйл ажиллагааг хэрхэн явуулах талаар сургалт зохион байгуулсан. Сургалтын гол зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоодын төлөөллөөс аливаа ослын үед тэдэнд тулгардаг хүндрэл бэрхшээл, аврах үйл ажиллагааг явуулж буй албан хаагчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харьцахад анхаарах асуудлын талаар санал бодлоо солилцох, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг яаж хүргэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аюулгүй байдлыг хэрхэн хангах, болзошгүй аюул, ослоос өөрийгөө болон бусдыг аврах, тусламж үзүүлэх мэдлэг, дадлыг нэмэгдүүлэх явдал байлаа.

### **3) Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ**

Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодит болгоё” Инчеоны стратегийн 7 дугаар зорилгын шалгуур үзүүлэлтийг хангахын тулд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Онцгой байдлын ерөнхий газар хамтран дараах ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөтэй болох;
- Холбогдох бүх үйлчилгээний ажилтнуудад зориулсан хөгжлийн бэрхшээлийг хамруулсан сургалтыг тогтмол хугацаанд хийж хэвших;
- Гамшгийн улмаас нас барсан болон ноцтой бэртсэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо, хохирлын талаар мэдээллийг албан ёсоор гамшгийн мэдээний бүртгэлд шинээр нэмж оруулан бүртгэх;
- Гамшгийн бэлэн байдлыг хангах болон гамшгийн үед авах арга хэмжээний үед ашиглах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан туслах тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх;



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны 2 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

### Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай

#### Нэгдүгээр бүлэг

#### Нийтлэг үндэслэл

##### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд оролцох тэгш эрх, түүнийг хангах, хэрэгжүүлэх, хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, оролцоо, баримтлах зарчмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэн болон Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

##### 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг;

4.1.2. “хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;

4.1.3. “тохирох хэрэглэгдэхүүн” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээг;

4.1.4. “түгээмэл загвар” гэж нэмэлт тохиргоо, тусгай загвар шаардахгүйгээр бүх хүн ашиглахад тохиромжтой, энгийн бүтээгдэхүүн, программ, орчин болон үйлчилгээний хэв маягийг;

4.1.5.“хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн амьдралд тэгш оролцох боломжийг бүрдүүлж, гэр бүл, хамт олны дунд эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэхийг;

4.1.6.“боломжит дээд хэмжээ” гэж тухайн хүний хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамаарч алдагдсан чадварыг нь сэргээж болох дээд хэмжээ;

4.1.7.“урьдчилан сэргийлэх” гэж иргэн, хамт олны оролцоотойгоор өвчин эмгэг, осол гэмтлийн эрсдэлээс хамаарах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах, өвчин эмгэгийг эрт илрүүлж эмчлүүлэх, тэдгээрээс үүдэн гарах эрүүл мэндийн болон нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулах үйл ажиллагааг;

4.1.8.“туслах хэрэгсэл” гэж биеийн бүтцийн гажиг, үйл ажиллагааны алдагдлыг орлох, засах, хамгаалах, дэмжих, гэмтэл учрахаас урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;

4.1.9.“асаргаа сувилгааны хэрэгсэл” гэж асруулж байгаа хүний эрүүл мэндийн хэвийн байдлыг хангах, асарч байгаа хүний хөдөлмөрийг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зориулалт бүхий хэрэгслийг;

4.1.10.“ариун цэвэр-эрүүл ахуйн материал” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүний өдөр тутмын эрүүл ахуйн шаардлагыг хангах, зайлшгүй хэрэгцээтэй материал хэрэгслийг;

4.1.11.“бие даан амьдрах эрх” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн өөртэй нь холбоотой аливаа асуудлаар бие даан шийдвэр гаргах, сонголт хийх, оролцох боломжийг;

4.1.12.“хөтөч нохой” гэж хараагүй хүн тухайн орчинд зөв чиг баримжаатай, саадгүй, аюулгүй зорчиход нь туслах зорилгоор тусгайлан сургаж, бэлтгэсэн нохойг;

4.1.13.“дохионы хэлний хэлмэрч, орчуулагч” гэж сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилдэг хүнийг.

## **5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим**

5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дараахь зарчмыг баримтална:

5.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих;

5.1.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний сонголт хийх эрх, хараат бус байдлыг хүндэтгэх;

5.1.3.сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгэмших зэрэг бүхий л харилцаанд оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг саадгүй, хүртээмжтэй хангах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;

5.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжих эрхийг хангах, тэдний онцлог байдлыг хүндэтгэх;

5.1.5.хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй хүргэх явдал нь бүх нийтийн үүрэг байх;

5.1.6.хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангах.

## Хоёрдугаар бүлэг

### Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх

#### 6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах

6.1. Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.

6.2. Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.

6.3. Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2- т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.3.1. нийтийн тээврээр зорчих, дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлээгүй байх;

6.3.2. хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээлэл авах, бусадтай харилцахад шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлээгүй байх;

6.3.3. хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, сурч боловсрох сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлэхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгэм, хамт олны дунд бие хүн болж төлөвших, хөгжихийг хязгаарлах, ялгавартай хандах;

6.3.4. хөгжлийн бэрхшээлтэй гэх шалтгааны улмаас зээл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;

6.3.5. хөгжлийн бэрхшээлтэй хүний нөхөн үржихүйн эрхийг өөрийн нь зөвшөөрөлгүйгээр хязгаарлах;

6.3.6. төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд оролцуулахаас татгалзах, зайлсхийх, сонгох, сонгогдох эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхгүй байх.

6.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т зааснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхгүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.4.1. ажлын байрны сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзах, сонгон шалгаруулалтад тэнцсэн хүнийг хөгжлийн бэрхшээлийн улмаас ажилд авахаас татгалзах;

6.4.2. хөдөлмөр эрхэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний албан тушаал ахих, дэвших боломжийг хязгаарлах;

6.4.3. байгууллага, аж ахуйн нэгж нь ажиллагсадыг хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварласан дүрэм, журам, удирдлагын арга барилыг хэрэглэх, ашиглах;

6.4.4. гэр бүлийн гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй гэсэн шалтгаанаар хүнийг ажилд авахаас татгалзах, чөлөөлөх, бусад хэлбэрээр ажил, хөдөлмөр эрхлэх эрхийг нь хязгаарлах;

6.4.5. хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдлэг ур чадвар, онцлогт тохирсон ажлын байрыг зохион байгуулахаас татгалзах, цалин хөлсийг ялгавартай тогтоох;

6.4.6.хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт тохирсон ажлын байрны тохирох хэрэглэгдэхүүн бий болгохгүй байх.

6.5.Дараах үйлдлийг бусад ялгаварлан гадуурхалт гэж үзнэ:

6.5.1.хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, эцэг эхийг гадуурхах, олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх, хүний сүсэг бишрэл, итгэл үнэмшилд суурилан хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхэд халдсан аливаа зөвлөгөө өгөх;

6.5.2.гэр бүлийн гишүүд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмээс тусгаарлах, нуух түүнийг нийгмийн харилцаанд оролцохыг аливаа хэлбэрээр хязгаарлах, хөгжүүлэх чадваржуулах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийх;

6.5.3.хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан хүнийг үр хүүхдээ асрамжиндаа авах эрхийг хязгаарлах.

6.6.Төрөөс хүнийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан бүх хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон, ялгаварлан гадуурхалтад өртөхөөс нь хамгаалсан нийгэм, эдийн засаг, хууль зүйн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

6.7.Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

6.8.Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралд тэгш оролцох эрхийг нь бодитой хангах зорилгоор онцлогт нь тохируулан авч хэрэгжүүлж байгаа тусгай арга хэмжээг ялгаварлан гадуурхалт гэж үзэхгүй.

## **7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх**

7.1.Гэр бүл болон нийгмийн бүхий л хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх зорилгоор төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.1.1.төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь ажилтан, албан хаагчдынхаа дунд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

7.1.2.Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар зөв ойлголтыг нийгэмд төлөвшүүлэхэд чиглэсэн нийтлэл, нэвтрүүлгийн бодлого хэрэгжүүлэх;

7.1.3.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хүндэтгэх эерэг хандлагыг төлөвшүүлэх асуудлыг бүх шатны боловсролын байгууллагын сурах бичигт тусгайлан тусгаж, сургалт, хичээлийн агуулгаар дамжуулан хэрэгжүүлэх;

7.1.4.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх болон төрөөс үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний гэр бүлд өгөх, сургалт, сурталчилгаа явуулах арга хэмжээг зохион байгуулах;

7.1.5.хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын бие даан амьдрах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх, эрхийг нь хүндэтгэсэн нийгмийн орчныг бүрдүүлэх, түүнд чиглэсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, гэр бүл, иргэдийн санал санаачлагыг дэмжих замаар нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаархи эерэг хандлагыг төлөвшүүлэх зорилгыг агуулсан арга хэмжээг зохион байгуулан холбогдох зардлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсөвт тусган шийдвэрлэх.

7.2.Энэ хуулийн 7.1-д заасан үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын оролцоог хангана.

7.3.Энэ хуулийн 7.1.4-т заасан арга хэмжээг зохион байгуулах ажлыг хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалдаг байгууллагатай гэрээгээр гүйцэтгүүлж болох ба холбогдох зардлыг Нийгмийн халамжийн сангаас гаргана.

## **Гуравдугаар бүлэг**

### **Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ**

#### **8 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний ажиллаж, амьдрах орчин, нөхцөлийг сайжруулах арга хэмжээ**

8.1.Орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

8.2.Нийтийн тээвэр, харилцаа холбоо, нийтийн үйлчилгээ, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй болгох, хиймэл эрхтэн, туслах болон асаргаа сувилгаа, ариун цэвэр-эрүүл ахуйн материал, хэрэгсэл, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.

8.3.Төрийн байгууллага нь нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, шаардлагатай стандарт, удирдамжийн баримт бичгийг боловсруулах, хяналт шалгалт хийх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, судалгаа шинжилгээ хийх, үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ба холбогдох зардлыг улсын төсөвт тусгана.

8.4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад хүртээмжтэй дэд бүтцийг сайжруулах, түүнд мэдээлэл харилцааны технологийг ашиглах боломжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэлтийг дэмжих, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс, хувцас, орон байр, ахуйн хэрэгслээр хангах арга хэмжээг авч, зардлыг барилга, зам, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн төсөвт тусган шийдвэрлэнэ.

#### **9 дүгээр зүйл. Орон сууц, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх**

9.1.Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй хүн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжид саадгүй хүрэх, тэдгээрийг чөлөөтэй ашиглах нөхцөлийг энэ хууль, хот байгуулалтын болон барилгын тухай хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэх ажлыг иргэн, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.

9.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн авто болон явган хүний зам, замын байгууламжийн заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилга, зам, тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.

9.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй буюу түүний хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн дэд бүтэц, орон сууц, олон нийтийн барилга байгууламжийн орчны болон дотоод зохион байгуулалтын заавал дагаж мөрдөх үндэсний стандартыг барилгын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.



9.4.Орон сууц, нийгмийн дэд бүтцийн байгууламжийг ашиглалтад оруулах барилгын комиссын бүрэлдэхүүний дөрөвний нэгд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.

9.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагыг хангаагүй барилга байгууламжийг улсын комисс хүлээж авахыг хориглоно.

#### **10 дугаар зүйл. Нийтийн тээврийн үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх**

10.1.Нийтийн тээврийн байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.

10.2.Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээнд нийцсэн нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоол, үйлчилгээний заавал мөрдөх үндэсний стандартыг тээвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын байгууллага батална.

10.3.Нийтийн тээврийн байгууллага энэ хуулийн 10.2-т заасан стандарт бүхий тээврийн хэрэгслийг ашиглах үүрэгтэй.

#### **11 дүгээр зүйл. Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх**

11.1.Мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.

11.2.Хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрх, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

11.2.1.төрийн байгууллагын цахим хуудас хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бий болгох;

11.2.2.хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан компьютерын дэлгэц дээрх бичгэн мэдээллийг дуу авиа руу хөрвүүлэн хувиргах дэлгэц уншигч, программ хангамж болон шинэ технологи, систем, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, тэдгээрийг эх хэл дээрээ ашиглах боломжийг бий болгох;

11.2.3.ном, сурах бичиг, сонин сэтгүүл, төрийн байгууллагын шийдвэр, албан бичиг, барааны шошго зэрэг бүх төрлийн хэвлэмэл материалыг хүртээмжтэй ашиглахад зориулсан бар кодтой хэвлэх;

11.2.4.цахим хуудас болон телевизийн мэдээ, мэдээлэл, танин мэдэхүйн болон өргөн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, текст унших боломжтой байдлаар нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

11.2.5.төрийн болон нийтийн үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй хүнд дохионы хэлний хэлмэрч, орчуулагч, бичигч, уншигч, хөтөчийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх;

11.2.6.хараа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүргэх зорилгоор байгуулагдсан ашгийн бус радио, телевизийг төрөөс дэмжих.

11.3.Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 11.2.1, 11.2.2, 11.2.3, 11.2.4-т заасан арга хэмжээний хэрэгжилтийг холбогдох байгууллагатай хамтран хангаж, шаардагдах зардлыг улсын төсөвт тусгуулах арга хэмжээ авна.

11.4. Сонсголын бэрхшээлтэй хүн цагдаа, эрүүл мэндийн байгууллага, онцгой байдлын албаны тусгай дугаарт текст мессэж, дохионы хэлний хэлмэрчийн зайн дүрс, ярианы тусламжтайгаар хандаж, үйлчилгээ авах боломжийг төрөөс бүрдүүлнэ.

## **12 дугаар зүйл. Монгол дохионы хэл**

12.1. Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй.

12.2. Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.

12.3. Энэ хуулийн 12.2-т заасан үйлчилгээг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

## **13 дугаар зүйл. Брайль үсгийн стандарт**

13.1. Брайль бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайль бичгийг ашиглан мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл боломжоор хангана.

13.2. Брайль үсгийн стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн стандартчиллын төв байгууллага батална.

### **Дөрөвдүгээр бүлэг Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх**

## **14 дүгээр зүйл. Сурч боловсрох эрх**

14.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн бусад иргэний хамт сурч боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй бөгөөд энэхүү эрхийг нь хангах чиглэлээр төрөөс дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

14.1.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлогт нийцүүлэн авьяас билэг, бүтээлч чанар, оюуны болон бие бялдарын чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, орчныг бий болгох;

